

“АЛТАНБУЛАГ” ЧӨЛӨӨТ БҮСИЙН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Зорилт 1. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилт.							
1.1	Засгийн газрын 36-р тогтоолын дагуу “Стратеги төлөвлөгөө” боловсруулах батлах, хэрэгжилтийг хангах журмыг үндэслэн 2021-2024 оны “Алтанбулаг” чөлөөт бүсийн дунд хугацааны “Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Алтанбулаг Чөлөөт бүсийн 2021-2024 оны дунд хугацааны стратеги зорилгын арга хэмжээ /№1, №2, №3/.	“Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2021-2024 оны “Дунд хугацааны стратеги төлөвлөгөө”-г боловсруулан 2021.01.12-нд Шадар сайдаар батлуулсан.	“Стратеги төлөвлөгөө” боловсруулах, хэрэгжилтийг хангах журмын дагуу 2021-2024 оны Алтанбулаг” чөлөөт бүсийн дунд хугацааны “Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт хангагдах.	1. “Алтанбулаг” чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах” төсөл арга хэмжээнд Барилга, Хот байгуулалтын сайдын багцаас 214.9 сая төгрөг олгогдсон. Тендер сонгон шалгаруулалтаар “Идеал групп” ХХК шалгарсан. 2022.10.03-ны өдөр “Идеал групп” ХХК, “Некст степ инженеринг” ХХК компаниудтай АБЧБ-ийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж буй ажлын явцтай танилцах уулзалт зохион байгуулсан. Мөн “Идеал групп” ХХК-аас ирүүлсэн 2022 оны 11.07-ны өдрийн 22/79 тоот албан бичгийн дагуу шаардлагатай нэмэлт материалуудыг өгсөн. Үүний дагуу тус гүйцэтгэгч компанитай Хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг хамтран зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж байна. 2. “Алтанбулаг” чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөлийн ажлын төсөв 15.6 тэрбум төгрөг бөгөөд улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд 1 тэрбум төгрөг батлагдсан. Үүнээс төсвийн тодотголоор 200 сая төгрөг олгогдсон. Цахилгаан хангамжийн өргөтгөлийн ажлыг “Улаанбаатар электрон монтаж” ХХК гүйцэтгэж байна. 3. БНСУ-ын KSP буюу мэдлэг солилцох хөтөлбөрийн хүрээнд “Алтанбулаг” чөлөөт бүсийн хөгжлийн боломж, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлох бодлогын судалгаа хамтран хийсэн. Судалгааны тайлан Эдийн Засаг, Хөгжлийн яаманд 2022.11.03-ны өдөр танилцуулагдсан.	100

1.2	Бодлогын баримт бичгүүд болон хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан “Чөлөөт бүсэд мөрдөх журам”-ын төслийг боловсруулах.	-	Хуулийн төсөлд саналаа хүргүүлэх.	“Зөвшөөрлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах саналаа хуулийн төслийн ажлын хэсэгт хүргүүлсэн.	Хуулийн төсөлд оруулсан саналаа хэвээр авч үлдэх.	Чөлөөт бүсийн эрх зүйн орчинг сайжруулах, Чөлөөт бүсийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх үүднээс ЭЗХЯ-ны сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж ажлын хэсэг шинээр “Чөлөөт бүсэд мөрдөх” журмын төсөл, “Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх”, “Чөлөөт бүсэд тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгох” зэрэг журмын төслүүдийг боловсруулж чөлөөт бүсэд хяналтын үйл ажиллагаа явуулж буй Гааль, татвар, хилийн цэрэг зэрэг байгууллагуудаас мөн хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдээс Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу санал авах ажил хийгдэж байна.	80
1.3	Бодлогын баримт бичгүүд болон хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан ОХУ-тай “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай” МУ, ОХУ-тай Засгийн газар хоорондын хэлэлцээрт санал оруулах	-	Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл.	2022 онд шинээр хийгдэх ажил	Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд саналаа оруулж холбогдох байгууллагад хүргүүлэх.	Монгол улсын ерөнхий сайдын 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 96 дугаартай ажлын хэсэг байгуулах тухай “Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөлт, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү ажлын хэсгийн зүгээс ЭЗХЯ-ны сайдаар ахлуулсан хийгдэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө батлагдаж төлөвлөгөөнд ОХУ-тай чөлөөт бүсийн чиглэлээр гадаад хамтын ажиллагааг идэвхижүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах, чөлөөт бүсийн бараа бүтээгдэхүүний экспорт, импортын гаалийн албан татварыг бууруулах саналыг ОХУ-ын талд хүргүүлэх, чөлөөт бүсээс ОХУ-ын Хиагт боомт руу шууд холбох гарц байгуулах зэрэг саналаа ЭЗХЯ-нд уламжилсан.	80
1.4	Гадаад, дотоодын хөрөнгө оруулагч ААН, байгууллагуудтай холбоо тогтоох, хамтран ажиллах.	-	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Хамтын ажиллагааны гэрээ, санамж	- Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийг байгуулах.	1. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны Дэд комиссын 15 дугаар хуралдаан тодорхой бүс хугацаагаар хойшлогдсон болно. 2. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 24, Монгол, Казахстаны Засгийн газар хоорондын комиссын ээлжит IX хуралдаануудын протоколд	100

			бичиг	<p>Засгийн газар хоорондын комиссын 23 дугаар хуралдаанд санал боловсруулан хүргүүлсэн. Энэхүү хуралдаан нь 2021 оны 11-р сарын 26-ны өдөр Улаанбаатар хотноо болж ЗГХК-ын протоколд тусгасан арга хэмжээнүүдийн хэрэгжүүлэх төлөвлөгөөий төсөлд “Алтанбулаг” чөлөөт бүсээс санал тусгаж боловсруулсан.</p> <p>- Монгол Улсын “Алтанбулаг” чөлөөт бүсийн</p>	<p>санал бэлтгэн хүргүүлсэн.</p> <p>3. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 24-р хуралдааны хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлсэн.</p> <p>4. Монгол-Оросын Засгийн Газрын 23-р хуралдаан, Бүс нутаг хил орчмын хамтын ажиллагааны Дэд комиссын 14-р хуралдааны хэрэгжилтийг бэлтгэн явуулсан.</p> <p>5. ГХЯ, ЭЗХЯ-нд Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник соёлын хамтын ажиллагааны Монгол-Казахстаны Засгийн газар хоорондын комиссын ээлжит 8 дугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явц бэлтгэн хүргүүлсэн.</p> <p>6. Бүх Оросын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн олон нийтийн байгууллагад чөлөөт бүсийн эрх зүйн орчны тухай тайлбар болон ерөнхий мэдээлэл өгсөн. Мөн тус байгууллагын Эрхүү мужийн салбарын дарга Р.Малиновский ахалсан бизнес эрхлэгч нартай хамтарсан уулзалт зохион байгуулсан.</p> <p>7. ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улстай хамтран ажиллах сайд Д.Ш.Чирипов тэргүүтэй “Экспортыг дэмжих төв”-ийн захирал Руслан Гылыпкылов ба бизнес эрхлэгч нартай холбоо тогтоож хамтын ажиллагаатай ажиллаж байна. /Танилцуулга хийгдсэн/</p> <p>8. ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын “Бүс нутгийн хөгжлийн сан”-ийн захирал Гэсэр Доржиев-ын ахалсан бизнес бүрэлдэхүүнтэй хамтарсан уулзалт зохион байгуулж, чөлөөт бүс дээр Буриадын бизнес эрхлэгч нарт чөлөөт бүсийн давуу тал, бизнес эрхлэх боломжийн талаар санал бодлоо солилцсон.</p> <p>9. 2022 оны 05-р сарын 27-28-ны өдрүүдэд ОХУ-ын БНБУ-д зохион байгуулсан “ОХУ-Монгол Улс шинэ бодит байдал дахь түншлэл” Эдийн засгийн форумд оролцож, энэхүү арга хэмжээний хүрээнд “Алтанбулаг” чөлөөт бүс болон ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын “Экспортыг дэмжих төв”-тэй “Хамтран ажиллах тухай” санамж бичиг байгуулсан.</p> <p>10. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бизнесийн Ерөнхий холбоо, Баяннуур хотын Худалдааг дэмжих салбар хорооны</p>
--	--	--	-------	--	---

				<p>зүгээс “Чөлөөт бүсийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Турк Улсын хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулсны хүрээнд Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Р.Болд мөн Монгол Улсад суух Бүгд Найрамдах Турк Улсын Элчин сайд ноён М.Ахмет Язал-д хамтран ажиллах тухай хүсэлт</p>	<p>Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газартай цахим сүлжээгээр холбоо тогтоон мэдээлэл солилцон ажилласан.</p> <p>11. БНХАУ-ын Шэнжэний чөлөөт бүстэй холбоо тогтоон хамтран ажиллах хүсэлтээ хүргүүлсэн.</p> <p>12. Турк-Монголын бизнес эрхлэгчдийн холбоотой холбоо тогтоож хоёр байгууллагын хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулахаар тохиролцон санамж бичгийн загварыг боловсруулан хүргүүлсэн. Тус холбооны ерөнхийлөгч өөрийн биеэр бүсийн ЗАА-ны удирдлагатай уулзалт хийх тухай хүсэлтээ илэрхийлж ажлын төлөвлөгөөний дагуу уулзалтын товыг товлон хариу мэдэгдэхээр тохиролцсон.</p> <p>13. Эдийн засаг, хөгжлийн яамны Хилийн боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газарт БНТУ-ын Худалдааны яамнаас зохион байгуулах айлчлалтай холбогдуулан зөвлөлдөх уулзалтын хүрээнд хэлэлцэх асуудлыг боловсруулж хүргүүлсэн.</p> <p>14. Эдийн засаг, хөгжлийн яамны Хилийн боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газарт Эдийн засаг худалдааны Монгол, Туркийн Засгийн газар хоорондын хамтарсан хорооны есдүгээр хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг боловсруулан хүргүүлсэн.</p> <p>15. Япон улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яамны хоёрдугаар нарийн бичгийн дарга бөгөөд Дэд консул Yoshikane Kazunori, Эдийн засгийн албаны дарга бөгөөд нэгдүгээр нарийн бичгийн дарга Ichika Akirатай уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтаар бүсийн дэд бүтцийн ажлын санхүүжилт, төсөл хөтөлбөрт хамрагдах талаар хэлэлцэж, тодорхой гарц гаргалааг гаргаж тайлбарыг өгсөн.</p> <p>16. Герман-Монголын бизнес эрхлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал Магнис Миллертэй уулзалт зохион байгуулж дараах асуудлаар ярилцаж санал бодлоо хуваалцсан.</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол Улс, ХБНГУ-ын чөлөөт бүсүүдийг хамтын ажиллагаатай болгоход мэдээлэл, зөвлөгөө өгч, зуучлах 2. Албан хаагчдыг чадавхжуулах сургалт, семинарт хамруулах 3. “Алтанбулаг” чөлөөт бүсийн үйл ажиллагааг Германы
--	--	--	--	---	--

			<p>явуулсан. -БНСУлсын төрийн өмчит байгууллага болох Котрагийн Монгол дахь салбар байгууллага тай 3 дахь удаагийн уулзалтыг цахимаар хийсэн. -Монгол, Японы Стратегийн түншлэлийн Дунд хугацааны хөтөлбөр (2021-2026)-т хамтран ажиллах тухай саналаа хүргүүлсэн.</p>	<p>бизнес эрхлэгчид болон Герман дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхим, мэргэжлийн холбоодуудад сурталчлан таниулах тал дээр дэмжлэг үзүүлэх</p> <p>17. ГХЯ, ЭЗХЯ, МҮХАҮТ-руу Монгол-Оросын хамтарсан “Монгол-Оросын олон улсын үзэсгэлэн худалдаа” зохион байгуулах талаар мэдээлэл хүргүүлсэн.</p> <p>18. Эдийн засаг, хөгжлийн яаманд чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөлт, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар мэдээллүүдийг нэгтгэн явуулсан.</p> <p>19. Эдийн засаг, хөгжлийн яамны Хилийн боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газарт Чөлөөт бүсэд хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, чөлөөт бүсийн хөгжлийг дэмжих, сурталчлах зорилго бүхий “Хөрөнгө оруулагчдын зөвлөл”-ийн бүрэлдэхүүний санал оруулж хөрөнгө оруулагчдын мэдээллийг хүргүүлсэн.</p> <p>20. “Алтанбулаг” чөлөөт бүсэд байгуулах ложистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах төслийн тухай танилцуулга бэлтгэж ШСАА-д хүргүүлсэн.</p> <p>21. ОХУ-ын “АМС Групп” ХХК-ний чөлөөт бүсэд химийн нэмэлтийн үйлдвэр барих тухай албан хүсэлт, АНЭУ-д төвтэй “Goodname” компанийн чөлөөт бүсэд түүхий никотиныг боловсруулж, цэвэр никотин гаргаж авах үйлдвэр байгуулах тухай хүсэлтийг орчуулан танилцуулж тус компанийн удирдлагуудад чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулахад шаардагдах мэдээллийг боловсруулж илгээсэн.</p> <p>22. ОХУ-ын “ТЛТ-Кяхта” ХХК, БНСУ-ын “Далай пада” ХХК-нуудын гаргасан хүсэлтийн дагуу чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах тухай мэдээ, мэдээлэл танилцуулга бэлтгэж, аман болон бичгийн орчуулга хийсэн.</p> <p>23. Чөлөөт бүсэд бүртгэлтэй хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийн нэгдсэн зөвлөлдөх уулзалт болон бүсэд байнгын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн удирдлагатай уулзах уулзалт арга хэмжээг зохион байгуулсан./ Нийт хөрөнгө оруулагч 108 аж ахуйн нэгж, байнгын үйл ажиллагаа явуулдаг 25 аж ахуйн нэгж оролцсон.</p> <p>24. Чөлөөт бүсэд хөрөнгө оруулах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх сонирхолтой гадаад улс орнуудын санал, гэрээ</p>
--	--	--	--	---

						хэлцлийн талаарх мэдээллийг боловсруулан ХБХОХ-т бэлтгэж өгсөн. 25. Хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөлд салбарын өнөөгийн байдлын тухай бэлтгэж хүргүүлсэн. 26. “Алтанбулаг” чөлөөт бүсийн дэлгэрэнгүй танилцуулгыг англи, орос, хятад хэл дээр орчуулан бэлтгэсэн.	
1.5	Төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах, гадаад дотоодод зохиогдож буй бизнес-форум, үзэсгэлэн яармагт оролцох ажлыг зохион байгуулах.	-	Ажлын тайлан	Мэргэжлийн байгууллагуудтай хийсэн “Хамтран ажиллах тухай” гэрээний дагуу хамтран ажилласан. - Монгол Улсын Алтанбулаг чөлөөт бүсийг хөгжүүлэх, тээвэр-логистикийн төв болгох чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол талын саналыг БН Казахстан Улсын Аж үйлдвэр, дэд бүтцийн хөгжлийн яам,	Хурал, зөвлөгөөн, бизнес-форум, үзэсгэлэн яармагт оролцсон тухай үр дүнг тайлагнаж, түүний мөрөөр тодорхой ажлуудыг гүйцэтгэсэн байна.	1. ОХУ, БНХАУ, БНКаЗУ, БНСУ, Япон Улс, БНТУ, БНБеларусь Улс, АНУ, ЕХ төлөөлөгчийн газар, ХБНГУ, БГВУ, БНЭУ, ИБУИНВУ-ын Монгол дахь элчин сайдын яамдуудад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, хамтран ажиллах тухай хүсэлт хүргүүлсэн. Эдгээрээс Турк, Япон, Энэтхэг, ХБНГУ, АНУ-ын ЭСЯ-дуудаас албан бичгээр хариу ирүүлсэн бөгөөд БНХАУ, БНБУ, БНСВУ, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын ЭСЯ-дуудаас утсаар холбогдон хариу ирүүлсэн. 2. Олон улсын байгууллагууд болох ЕСБХ, АХБ, Японы ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар, КОТРА Монгол дахь Төлөөлөгчийн газар, КОЙКА-гийн Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газар, НҮБ-ын Улаанбаатар дахь Олон Улсын Шилжих Хөдөлгөөний Байгууллагын салбар, ТИКА, ЕХ-ны Switch Asia хөтөлбөр, Япон Улсын засгийн газрын Буцалтгүй Тусламжийн “Өвсний Үндэс” Хөтөлбөр-т худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, чөлөөт бүсэд хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, хамтран ажиллах тухай хүсэлт бэлтгэж ЭЗХЯ-ны Хилийн боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газарт хүргүүлсэн. 3. ГХЯ-ны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газарт ОХУ-ын Эрхүү мужийн Амбан захирагч И.И.Кобзевын 12-р сард Монгол Улсад хийх айлчлалын хүрээнд “Алтанбулаг” чөлөөт бүсийн товч танилцуулга, холбогдох мэдээлэл хүргүүлсэн. 4. “Алтанбулаг” чөлөөт бүсийн ЗАА-аас ГЕГ-ын Мэдээлэл, технологийн газар, Хяналт шалгалтын газар болон Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын төлөөллүүдтэй хийсэн цахим уулзалтыг зохион байгуулсан. Тус хурлаар гаалийн деклораци шивэлтийг хөнгөвчлөх талаар хэлэлцэж, нэн тэргүүнд E-mongolia академийн дан системийг ашиглан урьдчилан мэдүүлэх нь оновчтой гэсэн шийдэлд хүрч,	100

			<p>Казахстаны Алматы мужийн захиргаа, “Казахстан Төмөр зам” хувьцаат нийгэмлэгээс харилцан ашигтай хамтын ажиллагааг өрнүүлэх боломжтой хэмээн үзсэн.</p> <p>- ЗТХЯ-тай хийх ажил хэргийн уулзалтаар хэлэлцэх асуудлуудыг боловсруулсан.</p> <p>- “Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, Татварын ерөнхий газартай хийсэн цахим уулзалтыг зохион байгуулж, зарим</p>	<p>холбогдох байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын баг гарч хамтран ажиллаж байна.</p> <p>5. ГХЯ, ЭЗХЯ, “Алтанбулаг” чөлөөт бүсийн ЗАА, АХБ-ны RIBS /Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл/-ийн хамтарсан уулзалтаас гарсан шийдвэрүүдийн дагуу асуудал шийдвэрлүүлэх тухай албан хүсэлтийг ГХЯ болон ЭЗХЯ-нд хүргүүлээд байна. Тус уулзалтаар “Алтанбулаг” чөлөөт бүсийн үйл ажиллагаа, шийдвэрлэх шаардлагатай ажлууд, сорилт ба шинэ боломжууд мөн Алтанбулаг боомтыг олон улсын жишигт нийцүүлэн өргөтгөн шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх бүтээн байгуулалтын ажлын явцын талаар тус тус зөвлөлдөн хэлэлцсэн болно.</p> <p>6. БНСУ-ын гадаад худалдаа хөрөнгө оруулалтын агентлаг “KOTRA”-д “Алтанбулаг” чөлөөт бүсийн товч танилцуулгыг солонгос хэл рүү орчуулан хүргүүлсэн.</p> <p>7. 2022 оны 06-р сарын 27- 29-ны өдөр Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулсан Монгол-Оросын хамтарсан “Монгол-Оросын олон улсын үзэсгэлэн худалдаа”-ны бэлтгэл ажил болох хөтөлбөр, илтгэл, презентаци, чөлөөт бүс дээрх үйл ажиллагаатай танилцах арга хэмжээг зохион байгуулж ажилласан.</p> <p>8. “Үндэсний дата төв”- тэй цахимаар холбогдож “Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны цахим шуудангийн админы нэвтрэх эрхийг сэргээж, мөн зарим албан хаагчдын цахим шуудангийн нэвтрэх нууц үгийг сэргээсэн. /мэдээллийн аюулгүй байдлын үүднээс 3 сар тутам нууц үг шинэчилж байна/</p> <p>9. ЭЗХЯ-нд ОХУ-ын БНБУ-ын хил орчмын бүс нутгийн иргэдийг иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах бичиг баримтаар зөвхөн “Алтанбулаг” чөлөөт бүсээр оруулж гаргах, гадаад паспортад нь “Алтанбулаг” чөлөөт бүс гэсэн дардас дарж шууд нэвтрэх боломжийн талаар ГХЯ-аар дамжуулан ОХУ-ын холбогдох байгууллагуудтай хамтран хил орчмын холбогдох гэрээ хэлэлцээрт нэмэлт өөрчлөлтүүдийг тусган эрх зүйн зохицуулалтыг хийх, “Алтанбулаг” чөлөөт бүсийн дэд бүтцийн, барилга байгууламжуудын ажлын санхүүжилтээс гадна Олон улсын байгууллагуудын төсөл, хөтөлбөрт хамруулах, хөрөнгө оруулалтыг татах хүсэлт хүргүүлсэн.</p> <p>10. Монгол улс болон ХБНГУ-ын Гадаад харилцааны яам</p>
--	--	--	--	--

			<p>асуудлуудыг шийдвэрлэл үүлсэн.</p> <p>- Монгол Улс дахь ОХУ-ын Худалдааны Төлөөлөгчийн газар, “Сбер банк России” /Оросын Хадгаламж банк/, ОХУ-тай хамтран ажиллах ажил хэргийн зөвлөл хамтран “Монгол Улсын худалдааны сүлжээнүүдэд ОХУ-ын сайн чанарын бараа бүтээгдэхүүнийг санал болгох хөтөлбөр”-ийг танилцуулах онлайн уулзалтанд оролцсон.</p> <p>- ОХУ-ын “Хаб-</p>	<p>хооронд зохион байгуулах улс төрийн зөвлөлдөх уулзалтад оруулах санал боловсруулан ЭЗХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>11. ГЕГазарт “ЭКСПО-2022” олон улсын үзэсгэлэн худалдааг зохион байгуулахтай холбогдуулан тус үзэсгэлэн худалдаанд оролцох гадаад, дотоодын компаниуд, чөлөөт бүсэд бүртгэлтэй ААН-үүдийн бараа бүтээгдэхүүний импорт, экспортын татвар, гаалийн хяналт шалгалтын горим, деклараци олголтыг хялбаршуулан ажиллах тухай албан бичиг боловсруулан хүргэж хамтран ажилласан.</p> <p>12. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮГазар болон НЖДҮГазарт “ЭКСПО-2022 олон улсын үзэсгэлэн худалдааг зохион байгуулахтай холбогдуулан уг арга хэмжээнд Улаанбаатар хот, дүүрэг, аймгуудын хоршоо, жижиг дунд үйлдвэрийн бизнес эрхлэгчдэд мэдээлэл хүргэж өргөнөөр оролцох боломжоор ханган дэмжлэг үзүүлэх хүсэлт гаргаж хамтран ажилласан.</p> <p>13. Хилийн цэргийн 0101-р ангид “ЭКСПО-2022 олон улсын үзэсгэлэн худалдааг зохион байгуулахтай холбогдуулан уг арга хэмжээнд оролцож байгаа бизнес эрхлэгч, төлөөлөгчдийг бүс рүү нэвтрэхэд бөөгнөрөл, дараалал үүсгэхгүйгээр хурдан шуурхай зохицуулж, хамтран ажиллах тухай хүсэлт гаргаж хамтран ажилласан.</p> <p>14. “Пи Си Молл” ХХК, “Номин холдинг” ХХК, “Нэкст электроникс” ХХК, “БСБ групп” компани, “Арина компьютерс” ХХК, “Мобиком корпораци”-уудад ЭКСПО-2022 олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцож хамтран ажиллах хүсэлт гарган амжилттай зохион байгуулсан.</p> <p>15. “Монголын эдийн засгийн форум”-ын хэлэлцүүлэгт тараагдах “Алтанбулаг” чөлөөт бүс”-ийн тухай товхимол танилцуулгад орох материалуудыг бэлтгэж хэвлүүлсэн. “Улаанбаатар түншлэл-2022” үзэсгэлэн худалдааны хүрээнд ОХУ-ын хөрөнгө оруулагчдад чөлөөт бүсийн тухай мэдээлэл хүргэсэн.</p> <p>16. ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын “Бүс нутгийн хөгжлийн сан”-аар дамжуулж Эрхүү мужийн бизнес эрхлэгч нарт чөлөөт бүсийн давуу тал, цаашдаа бизнес эрхлэх боломжийн талаар санал бодлоо цахимаар солилцсон.</p> <p>17. ОХУ-ын БНБУ-ын “Экспортыг дэмжих төв”, “Бүс нутгийн хөгжлийн сан”-тай тогтмол холбоотой ажиллаж байна.</p>
--	--	--	---	---

				Амитекс” компанитай хамтарсан уулзалт хийж, чөлөөт бүсийн үйл ажиллагааны талаар санал бодлоо солилцсон.		18. 2022 оны 1-р улиралд аймаг, суманд корона вирусын өвчлөл ихэссэн болон бүсээр нэвтрэх иргэдийн хөдөлгөөн их байсантай холбогдуулан Аймгийн онцгой комисс, Хилийн цэргийн 0101-р ангийн удирдлага, Гаалийн байгууллагын удирдлагуудтай хуралдсан. Үүнээс гарсан шийдвэрийн дагуу гаалийн байгууллагын ажилтанг нэмж бүртгэл хийх өрөө суллан гаргаж, байнгын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдтэй “Хариуцлагын гэрээ” байгуулж гэрээний хэрэгжилтийг хангуулж ажилласан. 19. МҮХАҮТ-тай хамтран Монгол улсаас гарал үүсэлтэй экспортын барааны гарал үүсэл тодорхойлох, гарал үүслийн гэрчилгээ олгох, баталгаажуулах талаар мэргэжлийн зөвлөгөө авах тухай хүсэлт гаргаж Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, онцлог, Монгол улсаас экспортын барааны гарал үүслийн гэрчилгээ авах, гарал үүсэл тодорхойлох үйл явц, Барааны тэмдгийн ерөнхий ойлголт, Экспертизийн үйлчилгээний танилцуулга сэдвээр сургалт авч “Алтанбулаг”, “Замын-Үүд”, “Цагааннуур”-ын чөлөөт бүсүүдийн ЗАА-ны хамт олонд сургалт зохион байгуулсан	
Зорилт 2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
2.1	Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, тэдгээртэй хөрөнгө оруулалтын болон газар эзэмшүүлэх гэрээ байгуулах, бүртгэлийн гэрчилгээ олгох, хувийн хэргийг бүрдүүлэх.	1,617,500 төгрөг /Улсын маягт хэвлүүлэх зардал/	Чөлөөт бүсийн бүртгэлийн гэрчилгээ, газрын болон хөрөнгө оруулалтын гэрээ, хувийн хэрг.	2021 оны байдлаар “Алтанбулаг” чөлөөт бүсэд нийт 137 аж ахуйн нэгж бүртгэлтэй байна.	Бүсэд үйл ажиллагаа эрхлэх ААН бүр журмын дагуу хуулийн этгээдийн бүртгэлд хамрагдаж, хувийн хэргийг бүрдүүлэх.	Чөлөөт бүсэд бүртгэлтэй нийт 139 ААН байна. 1. 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/46 дугаар захирамжаар “Алтанбулаг чөлөөт бүсэд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг олгох журам”-ыг боловсруулж, баталгаажуулсан. 2. 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/47 дугаар захирамжаар “Гэрээний загвар шинэчлэн батлах тухай” (Алтанбулаг чөлөөт бүсэд газар эзэмшүүлэх гэрээний загварыг 1 дүгээр хавсралтаар, Хөрөнгө оруулалтын гэрээний загварыг 2 дугаар хавсралтаар, барилга барих үйл ажиллагааны дэс дараалал, бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх актыг 4 дүгээр хавсралтаар) боловсруулж, баталгаажуулсан. 3. 2022 оны А/47 дугаартай захирамжаар газар эзэмшүүлэх, газар ашиглуулах гэрээ болон хөрөнгө оруулалтын гэрээний загварыг шинэчлэн баталсан. 4. 21 ААН-ийн хөрөнгө оруулалт, газар эзэмшүүлэх гэрээг	100

						шинэчлэн байгуулсан.	
2.2	Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах эсэх шийдвэр гаргах		Тусгай зөвшөөрөл .	2021 онд нийт согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй 17 ААН, Тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй 14 ААН байна.	ААН-д тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх тухай шийдвэрийг гаргана.	2022.11.30-ны өдрийн байдлаар: - Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй-22 ААН, - Тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй-19 ААН, - Эмийн сан-1, - Эм ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй-1 ААН байна.	100
Зорилт 3. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх							
3.1	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	688,800 төгрөг. /Ажил олгогч оос олгох 1 удаагийн тэтгэмж, урамшуулал/	Зэрэг дэв олгох, цалингийн шатлал нэмэгдүүлэх, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох, мэргэшлийн зэргийн цол, ур чадварын нэмэгдэл олгох, шагнах, урамшуулах, нөхөх төлбөр, тусламж	2017-2022 он хүртэл Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлан үе шаттайгаар хэрэгжүүлж байна.	Төрийн албаны тухай хууль, хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын дагуу төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх.	1. 2022.01.21-ний 01/21 албан тоотоор Улсын хоёрдугаар төв эмнэлгээр үйлчлүүлэх удирдах албан хаагчдын мэдээллийг хүргэсэн. 2. Улсын 1,2-р төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төвд тус тус албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах хүсэлтийг хүргүүлээд байна. 3. 2022.01.28-ны Б/03 тоот захирамжаар Цагаан сарын баярыг тохиолдуулан байгууллагаас тэтгэвэрт гарсан 1 ахмад настанд хүндэтгэл үзүүлсэн. 4. 2022.03.29-ний А/12 тоот захирамжаар албан хаагчдын өдрийн хоолны зардлыг 3000 төгрөг байсныг 6500 төгрөг болгон шинэчлэн баталсан. 5. 2022.04.11-ний Б/32 тоот захирамжаар сахиул Б.Бүтэмжид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон. 6. 2022.04.11-ний өдрийн Б/33 тоот захирамжаар Сэлэнгэ аймаг, Алтанбулаг чөлөөт бүсэд эргүүл, хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэн амралтын өдөр хуваариар ажилласан 18 албан хаагчид 16 цагийн нэмэгдэл хөлс олгосон. 7. 2022.04.18-ны Б/35 тоот захирамжаар ГЭЗХНХ-ийн дарга Ч.Уламбаярт шинэ төрсөн хүүхдээ асрах чөлөө болон	85

			олгох захирамж.			<p>дэмжлэг үзүүлэх тухай, 2022.04.18-ны Б/37 захирамжаар шинээр хүүхэд төрүүлсэн мэргэжилтэн Т.Цэрэнсоном, нярав О.Энхмаа нарт дэмжлэг үзүүлэх тухай тус тус захирамж гарсан.</p> <p>8. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж 2022.05.02-ны А/20 дугаар захирамжаар баталсан.</p> <p>9. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчидтай байгуулах Хөдөлмөрийн гэрээний загварыг шинэчлэн боловсруулж 2022.05.05-ны өдрийн А/21 тоот захирамжаар баталсан. Уг загварын дагуу төрийн үйлчилгээний албан хаагчидтай Хөдөлмөрийн гэрээг байгуулсан.</p> <p>10. Төрийн үйлчилгээний албан хаагчдын “Ур чадварын нэмэгдэл олгох журам”-ыг боловсруулан 2022.05.13-ны өдрийн А/24 дугаар захирамжаар баталсан.</p> <p>11. Бүртгэл санхүүгийн хэлтсийн Бүртгэл хариуцсан мэргэжилтэн Г.Тамирыг “Алтангадас” одонгоор шагнуулахаар нэр дэвшүүлж 2022.05.24-ний 01/256 албан тоотоор Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.</p> <p>12. 2022 оны 2022.09.30-ны Б/74 тоот захирамжаар Ахмадын баярыг тохиолдуулан байгууллагаас тэтгэвэрт гарсан 3 ахмад настанд хүндэтгэл үзүүлсэн.</p> <p>13. 2022.09.01-ний Б/68 тоот захирамжаар Бүртгэлийн мэргэжилтэн О.Энхмаад 1 нас хүртэлх насны хүүхдээ хөхүүлэх, асрах 1 цагийн цалинтай завсарлага олгож байна.</p> <p>14. Албан хаагчдын спорт, биеийн тамирын арга хэмжээг тогтмолжуулах зорилгоор 2022.09.30-ны өдрөөс эхлэн 2 долоо хоног тутамд 1 удаа Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх спорт зааланд хичээллэж байна.</p>	
3.2	Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	494,000 төгрөг. /хичээл, үйлдвэрлэлийн зарда	Сургалтын хөтөлбөрийн үр дүнг илтгэсэн тайлан.	2021 оны байгууллагын сургалтын хөтөлбөрийг баталж хэрэгжүүлсэн. 1 албан хаагчийг мэргэшүүлэ	Хөтөлбөр боловсруулж хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчийг зохих сургалтад хамруулж үр дүнг тооцсон	<p>- 2022 онд Удирдлагын академиас улсын төсвийн санхүүжилтээр сургах сургалтад дараахь албан хаагчид хамрагдсан. Үүнд:</p> <p>1. “Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны зайн сургалт”-д Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн Л.Батболд, Бүртгэл хариуцсан мэргэжилтэн Ж.Солонго, Гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ц.Ундармаа нар хамрагдаж төгссөн.</p>	100

		л/	х багц сургалтад, 5 албан хаагчийг богино хугацааны сургалтад, нийт албан хаагчдыг 6 удаагийн нийтийг хамарсан цахим сургалтад тус тус хамруулсан.	байна.	<p>2. “Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх хугацааны сургалт”-д Гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ц.Ундармаа хамрагдаж төгссөн.</p> <p>3. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны зайн сургалтад Гэрээ эрх зүй хариуцсан мэргэжилтэн М.Намуун, Стратеги төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Э.Номундарь нар хамрагдаж төгссөн.</p> <p>4. “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын шинэчлэл” сэдэвт богино хугацааны зайн сургалтад ГЭЗХНХ-ийн дарга Ч.Уламбаяр, мэргэжилтэн Д.Рэнцэнмядаг, Ш.Пунцагбалжир, Д.Хулан нар хамрагдсан.</p> <p>5. “Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг” сэдэвт богино хугацааны зайн сургалтад мэргэжилтэн Ж.Нарангэрэл, Г.Баярсайхан, Х.Дөлгөөнбаяр, Бичиг хэрэг архивын ажилтан С.Мөнхзул нар хамрагдсан.</p> <p>6. “Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалт”-д Мэргэжилтэн О.Сувдаа, Нярав С.Гантөр, Жолооч С.Димитрис нар хамрагдан суралцаж байна.</p> <p>7. “Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт”-д Гэрээ эрх зүй, хүний нөөцийн хэлтсийн Гэрээ эрх зүй хариуцсан мэргэжилтэн Д.Рэнцэнмядаг суралцаж байна.</p> <p>8. “Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт”-д Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтсийн Дулааны хангамж хариуцсан мэргэжилтэн Г.Баярсайхан суралцаж байна.</p> <p>9. “Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг” сэдэвт танхим болон зайн хосолсон сургалтад мэргэжилтэн Ш.Пунцагбалжир, О.Сувдаа, С.Гантөр, С.Мөнхзул нар хамрагдаж төгссөн.</p> <p>10. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилт “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны 40 цагийн цахим болон танхим хосолсон сургалтад ХБХОХ-ийн дарга Э.Содномпил, Ахлах мэргэжилтэн М.Занданжав, Ерөнхий нягтлан бодогч</p>
--	--	----	--	--------	---

						<p>Э.Эрдэнэтуяа, мэргэжилтэн Х.Зоригт, Ж.Нарангэрэл нар хамрагдсан.</p> <p>- Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 арга зүйн сургалтад нийт албан хаагчид 7 хоног бүрийн Пүрэв гаригт цахим сургалтад хамрагдаж байна.</p> <p>- Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн Эрчим хүчний сургуулиас Эрчим хүчний Яамтай хамтран зохион байгуулдаг “Анхан шатны төсөвчин”-ий эрх олгох сургалтад Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтсийн Усан хангамж хариуцсан мэргэжилтэн О.Сувдаа 09.05-09.16-ны өдөр хамрагдаж төгссөн.</p>	
3.3	<p>Хүний нөөцийн систем hr.csc.gov.mn сайтад хүний нөөцийн мэдээллийг тогтмол оруулах. Хуулийн үйлчлэлд хамаарах албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулах meduuleg.iaac.mn сайтад оруулах, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах.</p>	-	<p>Хүний нөөцийн системийн мэдээлэл. ХОМ, ХАСУМ.</p>	<p>Хүний нөөцийн системд албан хаагчдын мэдээллийг бүрэн оруулсан. Хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлсэн.</p>	<p>meduuleg.iaac.mn, hr.csc.gov.mn сайтад албан хаагчдын мэдээллийг оруулах, мэдээ тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх.</p>	<p>1. 2022 онд Төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн системд /hrm.csc.gov.mn/ байгууллага болон албан хаагчдын ажлын түүхийг үүсгэж, хувийн, боловсролын, туршлагын, албан тушаалын, цалингийн мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулж байна.</p> <p>2. 2022 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн болон үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн нийт 19 нэр дэвшигчийн ХАСУМ болон албан тушаалын тодорхойлолтын хамт АТГ-т хянуулахаар хүргүүлснийг хуульд заасан үндэслэлийн дагуу хянан үзээд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул тухайн сул орон тоонд томилж Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасны дагуу томилогдсоноос хойш 30 хоногийн хугацаанд хувийн ашиг сонирхлыг мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулж ажилласан. Мөн 2021 оны шинэчилсэн ХАСХОМ гаргах 18 албан хаагчийн ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд гарган баталгаажуулж, холбогдох тайлангуудыг дээд шатны эбат-д хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан. 2022 оны бүтэн жилийн байдлаар албан тушаалын чиг үүрэг өөрчлөгдсөн болон сул орон тоонд нэр дэвшүүлсэн 19 албан хаагчийн ХАСУМ-ыг АТГ-т хянуулж ашиг сонирхлын зөрчил тогтоогдоогүй тул нэр дэвшүүлсэн албан тушаал болон чиг үүрэг өөрчлөгдсөн албан тушаалд тус тус томилж холбогдох хууль тогтоомжийн дагуу ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргуулан авч бүртгэлийн программд баталгаажуулсан.</p>	100
3.4	Албан тушаалын	-	Байгууллаг	2022 онд	Байгууллагын	1. 2022.06.07-ны 01/281 дугаар албан тоотой Сэлэнгэ	90

	сул орон тоог нөхөх, Төрийн албан хаагчийн хувийн хэргийг бүрдүүлэх, шинэчлэх.		ын сул орон тоог нөхөх захиалга өгсөн албан бичиг, Төрийн албан хаагчийн хувийн хэрэг.	шинээр хийгдэх ажил	сул орон тооны захиалга өгсөн байх. Албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг хангасан байх.	аймгийн ТАЗ-ийн салбар зөвлөлд Бүртгэл, санхүүгийн хэлтсийн Бүртгэл хариуцсан мэргэжилтэн, Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтсийн Барилгын асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоо, 2022.06.08-ны 01/284 дугаар албан тоотой Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн албаны салбар зөвлөлд Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтсийн Усан хангамж хариуцсан мэргэжилтний тус тус сул орон тооны захиалгыг хүргүүлсэн. 2. 2022 онд Төрийн захиргааны 9, төрийн үйлчилгээний 4, гэрээт 1, нийт 14 албан хаагч шинээр ажилд томилогдож тэдгээр албан хаагчдын хувийн хэргийг бүрдүүлсэн. 3. 8 албан хаагчийг өөрсдийн хүсэлтээр ажлаас чөлөөлж, 1 гэрээт ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосон. 4. 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар ЗАА нь нийт 42 орон тоотой, 39 албан хаагч ажиллаж, 1 албан хаагч хүүхэд асрах түр чөлөөтэй, 1 албан хаагч 6 сарын хувийн чөлөөтэй байна. 5. Төрийн албаны зөвлөлийн 2022.06.07-ны 02/1251 албан тоотой Төрийн албаны сул орон тоог нөхөх ажлыг харьяаллын дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны салбар зөвлөлд хүргүүлж ажиллахыг мэдэгдсэн. Өнөөдрийн байдлаар ЭЗХЯ-ны төрийн албаны салбар зөвлөл хараахан байгуулагдаагүй тул байгуулагдсан даруйд сул орон тооны захиалгыг хүргүүлнэ.	
3.5	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан гаргах, архив, албан хэрэг хөтлөлтийг журмын дагуу явуулах.	-	Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, албан хаагч, нэгж тус бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан.	Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг гаргасан. 2021 онд байгууллагад Ирсэн албан бичиг-302, явуулсан албан	Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, албан хаагч, нэгж тус бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан баталгаажсан байна. Архив, албан хэрэг хөтлөлт	1. Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах Төсвийн шууд захирагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө буюу байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгжүүдээс нэгтгэн боловсруулж, Эдийн засаг хөгжлийн яаманд хүргүүлсэн. 2. “А” буюу “Үндсэн үйл ажиллагааны чиглэл”-ээр 85 захирамж, “Б” буюу “Боловсон хүчний чиглэл”-ээр 81-н захирамж, нийт- 166 захирамж гарсан. - Явуулсан албан бичиг 455, - Ирсэн албан бичиг 437 ба Үүнээс: хариутай, шийдвэрлэх албан бичиг- 295, шийдвэрлэгдсэн-285, хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн-2 албан бичиг байна. 3. Албан хаагчдын 1 дүгээр улирлын гүйцэтгэлийн	100

			Архив, албан хэрэг хөтлөлтийн бүртгэл.	бичиг-265, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 83 захирамж, хүний нөөцийн чиглэлээр 51 захирамж тус тус гарч хугацаанд нь шийдвэрлэсэн. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж үүсгэсэн.	журмын дагуу бүртгэл хийгдсэн байх.	<p>төлөвлөгөөний тайлан, үнэлгээг нэгтгэн авч, түүний үнэлгээнд үндэслэн Захирагчийн 2022.04.12-ны өдрийн Б/34 захирамжаар 1 дүгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулыг 29 албан хаагчид олгосон.</p> <p>4. Захирагчийн 2022.06.08-ны өдрийн А/34 дүгээр захирамжаар байгууллагын үнэлгээний багийг байгуулсан. Үнэлгээний баг 2022.06.20-ны өдрийн дотор албан хаагчдын үнэлгээг баталгаажуулж захирагчид хүргүүлэхээр ажиллаж байна.</p> <p>5. БНШК-ын журмыг 2022.05.18-ны А/27 захирамжаар шинэчлэн баталсан.</p> <p>6. ХХНЖ-ыг БНШК-ын хурлаар хэлэлцэн акт үйлдсэн.</p> <p>7. 2022.06.08-ны өдрийн А/34 дүгээр захирамжаар байгууллагын үнэлгээний багийг байгуулсан. Үнэлгээний баг 2022.06.20-ны өдрийн дотор албан хаагчдын үнэлгээг баталгаажуулсан.</p> <p>8. Албан хаагчдын 2022 оны хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан үнэлгээнд үндэслэн 2022.07.18-ны өдрийн Б/58 захирамжаар 2 дугаар улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулыг 29 албан хаагчид олгосон.</p> <p>9. 2022.07.18-ны өдрийн Б/59 тоот захирамжаар 2 албан хаагчийн цалингийн шатлалыг алгасуулан нэмэгдүүлсэн.</p> <p>10. 2022.07.18-ны өдрийн Б/57 тоот захирамжаар Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтын дагуу Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон.</p> <p>11. 2022.10.19-ний Б/76 тоот захирамжаар 33 албан хаагчид 3 дугаар улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгосон.</p> <p>12. Архивт хадгалагдаж буй баримтуудаас албан хаагчдад шаардлагатай үед 454 баримтуудыг хувилж, ашиглалтын бүртгэл хөтлөн ажилласан.</p>	
3.6	“Алтанбулаг” чөлөөт бүсийн санхүүгийн тайлан балансыг хугацаанд нь гаргаж, холбогдох дээд	4.0 сая төгрөг /Аудит баталгаажуу	Санхүүгийн тайлан. Аудитын тайлан.	Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж харьяа дээд	Хагас, бүтэн жилийн тайланг баталгаажуулан гаргаж холбогдох байгууллад	<p>1. 2021 санхүүгийн баримтуудыг үдэж аудитын шалгалтаар оруулж баталгаажуулсан.</p> <p>2. 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд “Стандарт дүгнэлт аудит” ХХК-ний аудит хийлгэж зөрчилгүй саналгүй дүгнэлт авсан.</p> <p>Аудитаар ирүүлсэн маягтын дагуу үндсэн хөрөнгө, цалин хөлс,</p>	100

	шатны байгууллагуудад хүргүүлэх, аудитын байгууллагаар баталгаажуулж, сангийн яамны программд оруулах.	лалтын зардал/		байгууллагад хүргүүлж, аудитын байгууллагаар баталгаажуулсан.	хууль журмын хугацаанд хүргүүлсэн байна.	бараа материал болон холбогдох мэдээлэл судалгааг гаргаж өгсөн. Харьяа дээд байгууллага, Сангийн яам, Үндэсний аудитын газраас ирүүлсэн мэдээ, судалгааг цаг тухай бүрд хийж гүйцэтгэсэн.	
3.7	“Алтанбулаг” чөлөөт бүсийн ирэх 2023 оны жилийн төсвийн төсөөллийг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн боловсруулж дээд шатны байгууллагад танилцуулж батлуулах, мөн батлагдсан хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	-	2023 оны төсөв, төсвийн төсөөлөл.	Чөлөөт бүсийн 2021 оны төсөв, 2022-2023 оны төсвийн төсөөлөл боловсруулсан Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн.	Чөлөөт бүсийн 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөллийг боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх.	1. “Алтанбулаг” чөлөөт бүсийн 2022 оны батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах ажлын дагуу Түлш, халаалтын зардал нь хүйтний улиралд их гарч байгаа тул 6,7,8 дугаар сард тавигдсан улсын төсвийн санхүүжилтийг 1,2,3,4,5,9,10,11,12 дугаар саруудад шилжүүлж батлуулсан. 2. Чөлөөт бүсийн 2022 оны төсвийн төсөл, 2023-2022 оны төсвийн төсөөллийг боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яамд хүргүүлсэн. Үүнд: - Байгууллагын 2023 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг боловсруулах ажлын хүрээнд 2023 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын нийт 126 асуултыг боловсруулж https://publicinvestment.gov.mn/ шивж оруулан, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. - “Алтанбулаг” чөлөөт бүсийн хүзүүвчний хэсгийн 0,81 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажил. - Сэлэнгэ аймаг, Алтанбулаг сум “Алтанбулаг” чөлөөт бүсийн 13.7 авто замын ажил. - Гаалийн байгууллагын теле хяналтын “Genetic” систем. - “Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба, мэргэжлийн хяналтын А,В лаборатори барилга. - “Алтанбулаг” чөлөөт бүсийн холбооны гол худаг, сувагчлалын байгууламжийн барилга угсралтын ажил.	100
3.8	Чөлөөт бүсийн 2021 онд батлагдсан төсвийг Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 14-ны өдрийн 55 дугаар тушаал, 2021 оны 190 дүгээр	Төсөвлөгдсөн дүн	2023 оны төсөв, төсвийн төсөөлөл.	Нийт албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах	“Алтанбулаг” чөлөөт бүсийн албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй	1. Сар бүр ажилчдын урьдчилгаа болон гарт олгох цалин хөлсийг хууль тогтоомжийн дагуу Төрийн албаны цалингийн нэгдсэн систем болон санхүүгийн программ дээр бодож олгосон. 2. 2022 оны 1-12-р саруудын нийгмийн даатгалын цахим тайланг гаргаж баталгаажуулав. 3. 2022 оны 1,2,3,4-р улирлын ХХОАТ-н тайланг гаргаж харьяа татварын албаар баталгаажуулсан.	100

	тушаалын дагуу зарцуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргах. “Алтанбулаг” чөлөөт бүсийн албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах орлогуудыг цагийн бүртгэлийн дагуу бодож, тухайн жилийн ээлжийн амралтыг тооцон хүн тус бүрд олгож холбогдох тайланг хуулийн хугацаанд гаргах.			орлогуудыг цагийн бүртгэлийн дагуу бодож, тухайн жилийн ээлжийн амралтыг тооцон хүн тус бүрд олгож холбогдох тайланг хуулийн хугацаанд гаргасан.	адилтгах орлогуудыг цагийн бүртгэлийн дагуу бодож олгосон, холбогдох тайланг хуулийн хугацаанд гаргаж баталгаажуулсан байна.	4. Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргаж Эдийн засаг хөгжлийн яаманд холбогдох мэргэжилтэнд цахимаар илгээсэн. 5. Шилэн дансны хөтлөлтийг холбогдох заалтын дагуу сар бүр хуулийн хугацаанд хийж гүйцэтгэж байна.	
3.9	Үндсэн хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр хийж ТӨБЗГ-ын өмч хөрөнгийн программд хөдлөл өөрчлөлтийг оруулж, хуримтлагдсан элэгдэл дууссан компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад хангамжийн материалын жагсаалтыг бэлтгэж байгууллагын өмч хамгаалах байнгын	-	Үндсэн хөрөнгийн тооллогын хагас бүтэн жилийн тайлан,	2020 оны үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг хийж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын мэдээлэлжүүлэлтийн системд шивж оруулж гэрээг дүгнэсэн,	Үндсэн хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр хийх, ТӨБЗГ-ын өмч хөрөнгийн программд хөдлөл өөрчлөлтийг оруулах, шаардлагатай материалыг актлах шийдвэр гаргах.	- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын статистик маягтын дагуу 2021 оны үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн статистик мэдээг хийж баталгаажуулав. - 2022 оны байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийн хагас жилийн тооллогыг хийсэн.	100

	зөвлөлөөр хянуулж, ТӨБЗГ-аар актлах шийдвэр гаргуулах.			статистик мэдээг гаргасан. 2021 оны хагас болон бүтэн жилийн үндсэн хөрөнгийн тооллогыг хийсэн.			
3.10	2022 онд “Алтанбулаг” чөлөөт бүсэд бүртгэлтэй ААН-ээс газрын төлбөрийн үлдэгдлийг шүүхийн байгууллагаар нэхэмжлэх, үйл ажиллагаа эхлүүлээгүй ААН-ийн чөлөөт бүсэд эзэмшиж буй газар эзэмших эрхийг цуцлах	Шаард агдах төсөв оруулах	ААН-д гаргасан нэхэмжлэх . Газар эзэмших эрх цуцлах захирамж.	2014 оноос өмнө чөлөөт бүсэд газар эзэмших эрх нь цуцлагдсан болон сүүлийн 3-5 жилийн хугацаанд газрын төлбөрөө төлөөгүй 91 аж ахуйн нэгжийн газрын төлбөрийн үлдэгдэл болох 1.1 тэрбум төгрөгийг 2021 оны 12 дугаар сарын байдлаар 330 сая болгон бууруулан	ААН-үүдтэй газрын төлбөрийн тооцоо нийлэх акт үйлдэх, газрын төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх, жилийн эцсийн тайланг баталгаажуулах.	<u>ШШГГ-т гүйцэтгэх ажиллагаа явагдаж газрын төлбөрийг барагдуулсан ААН:</u> -“Эв од импекс” ХХК 4.200.000₮ -“Монфреш шүүс чөлөөт бүс” ХХК 1.400.000₮ -“ Монфреш шүүс чөлөөт бүс” ХХК 4.000.000₮ -“Мегаватт чөлөөт бүс” ХХК 3.387.180₮ -“Тусжин чөлөөт бүс” ХХК 3.300.000₮ <u>ШШГГ-т гүйцэтгэх ажиллагаа явагдаж газрын төлбөрийг хэсэгчлэн барагдуулж байгаа ААН:</u> -“ Сэлэнгэ хөх чоно” ХХК 350.000₮ <u>Газрын төлбөр бүрэн төлсөн ААН-үүд</u> -“Алтанбулаг ирээдүй чөлөөт бүс” ХХК 13.399.800₮ -“Уян хуст чөлөөт бүс” ХХК 4.524.000₮ -“Шинобу финанс чөлөөт бүс” ХХК 4.800.000₮ -“Ноён заамар чөлөөт бүс” ХХК 4.800.000₮ -“Хан судар чөлөөт бүс” ХХК 7.200.000₮ <u>Газрын төлбөрийг хэсэгчлэн төлж байгаа ААН:</u> -Ханяан чөлөөт бүс ХХК 1,300.000₮ <u>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу төлбөрийг хэсэгчлэн төлж шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хаалгасан ААН:</u> -“Бизнес контакт” ХХК 8.870,472₮ Газар эзэмших эрх цуцлах тухай мэдэгдэх албан бичиг доорх	90

			<p>ажиллаж байна.</p> <p>Шийдвэрлэлт: Дээрх 91 ААН-ийг 2018 оноос эхлэн харьяа дүүргийн ИХАШШ-д нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлэхээр ажиллаж эхэлсэн бөгөөд 2019 онд 367.187.560 ₮, 2020 онд 385.899.490 ₮, 2021 онд 93.197.713₮-ийг тус тус хэрэгсэхгүй болгон шийдвэрлүүлж 2021 оны 12 дугаар сарын байдлаар 330.801.457 ₮-ийн үлдэгдэлтэй байна. 2021 оны 12 дугаар сарын байдлаар:</p>	<p><u>ААН-үүдэд хүргүүлсэн. Үүнд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Удвал их наран чөлөөт бүс ХХК - Ханян чөлөөт бүс ХХК - Ньюбатням чөлөөт бүс ХХК - Оргил тайж чөлөөт бүс ХХК - Нарны буман гэрэл ХХК - Насны зам ХХК - Ноён заамар чөлөөт бүс ХХК <p>Мегаватт чөлөөт бүс ХХК-д газрын төлбөр төлүүлэх тухай мэдэгдлийг хүргүүлсэн.</p> <p><u>2022.04.17-ны өдөр чөлөөт бүс дэхь хуулийн этгээдийн бүртгэлээс хасч, газар эзэмших эрхийг цуцласан ААН-үүд</u></p> <ul style="list-style-type: none"> -Удвал их наран чөлөөт бүс ХХК -Ханян чөлөөт бүс ХХК -Ньюбатням чөлөөт бүс ХХК /2га/ -Оргил тайж чөлөөт бүс ХХК -Нарны буман гэрэл чөлөөт бүс ХХК нарыг 2022.06.02-ны өдөр газрын төлбөрийн үлдэгдлийг харьяалах шүүхэд нэхэмжлэл гаргасан. <p>Шүүхийн шийдвэр гарч, тохиролцсон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлээгүй доорхи ААН-үүдэд гүйцэтгэх хуудас гаргуулах тухай хүсэлт гаргасан</p> <ul style="list-style-type: none"> -Алтан үрэл ингэт трейд ХХК -Тусжин чөлөөт бүс ААК -Дөрвөн ивээл ХХК -Сэрэнгэт чөлөөт бүс ХХК <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгох тухай 5 ААН-ийн мэдэгдлийг хүргүүлсэн.</p> <p>Чөлөөт бүсэд бүртгэлтэй үйл ажиллагаа эхлээгүй 92 ААН-д сонсох ажиллагаа явуулах тухай мэдэгдлийг гаргаж хүргүүлсэн.</p> <p>Шүүхийн шатанд байсан “Өгөөмөр баян булаг чөлөөт бүс” ХХК /3,6га/-ийн хяналтын шатны шүүх хуралдаан 2022.09.22-ны</p>
--	--	--	--	--

			<p>- Шүүхийн шатны ажиллагаанд байгаа- 1 ААН</p> <p>- Цагдаагийн байгууллагаар эрэн сурвалжлагдаж байгаа- 8 ААН</p> <p>- Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр ШШГБ-р шийдвэрлүүлж буй- 12 ААН.</p> <p>2021 оны 12 дугаар сарын 14-ний байдлаар газрын төлбөрөөс 111,308,339 төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн.</p> <p>Гэрээ байгуулж</p>	<p>өдөр болж, тус шүүхийн 001/ХТ2022/00840 дугаартай тогтоолоор нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, 5,111,014 төгрөгийг төлүүлэхээр шийдвэрлүүлсэн.</p> <p><u>2022.04.17-ны өдрийн тус чөлөөт бүсийн Захирагчийн захирамжаар газар эзэмших эрх нь цуцлагдсан 5 ААН:</u></p> <p>-“Ньюбатням чөлөөт бүс” ХХК хаяг тодорхойгүй гэх үндэслэлээр 2022.06.28-ны өдрийн 181/ШЗ2022/08755 дугаартай СБД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болж, дахин эрэн сурвалжлуулах тухай нэхэмжлэл гарган 2022.07.25-ны өдрийн 181/ШШ2022/01618 дугаартай шийдвэрээр цагдаагийн байгууллагаар эрэн сурвалжлагдаж байна.</p> <p>-“Удвал их наран чөлөөт бүс” ХХК 2022.06.02-ны өдөр БГД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч ИХШХШТХ-ийн 65.1.2-т зааснаар шүүхийн харьяалах маргаан биш гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамж гарсан. Дахин хаяг тодорхой болгож СБД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан.</p> <p>-“Оргил тайж чөлөөт бүс” ХХК 2022.09.16-ны өдөр шүүх хуралдаан болж, БЗД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн “нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, татварын хөнгөлөлт үзүүлэх тухай” захирамжаар шийдвэрлүүлсэн.</p> <p>-Нарны буман гэрэл чөлөөт бүс” ХХК БЗД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022.07.07-ны өдрийн 101/ШШ2022/03237 дугаартай шийдвэрээр газрын гэрчилгээ гаргаагүй, газрыг актаар хүлээлгэж өгөөгүй гэх үндэслэлээр нэхэмжлэл гаргах эрхгүй гэж үзэн тус нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.</p> <p>-“Ханян чөлөөт бүс” ХХК-г Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан. 2022.10.04-ны өдрийн 182/ШШ2022/02818 дугаартай ЧД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар нэхэмжлэлийн</p>
--	--	--	--	--

				байгаа ААН-үүдын газрын төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулж, хяналт тавьж ажилласан.		шаардлагыг хангаж шийдвэрлүүлсэн. <u>Шүүхийн шийдвэрээр бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн ААН-үүд:</u> “Нарны буман гэрэл чөлөөт бүс” ХХК-ийн 5.100.000₮ “Оргил тайж чөлөөт бүс” ХХК-ийн 5.100.000₮ 2022.10.13-ны өдөр чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлээс хасч, газар эзэмших эрх нь цуцлагдсан дараах ААН-ийн: -Сэрэнгэт чөлөөт бүс ХХК -Нэг бүс чөлөөт бүс” ХХК -Алтанбулаг рекс чөлөөт бүс ХХК -Наран энерги трейд чөлөөт бүс ХХК -Юниверсал констракшн чөлөөт бүс ХХК нарт харьяалах шүүхэд нэхэмжлэл гарган хүргүүлсэн. Одоогийн байдлаар товлогдсон шүүх хуралдаан байхгүй, шийдвэр гараагүй байна.	
3.11	Чөлөөт бүсэд газар эзэмших болон хөрөнгө оруулалтын гэрээтэй аж ахуйн нэгжүүдтэй газрын төлбөрийг тооцоолж, аж ахуйн нэгжтэй тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах.	-	Газрын төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлсэн баримт.	Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжээс 65,5 сая төгрөг, нийт газрын төлбөр 83,9 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн.	ААН-үүдтэй газрын төлбөрийн тооцоо нийлэх акт үйлдэх, газрын төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх, жилийн эцсийн тайланг баталгаажуулах.	2022 оны 11 дугаар сарын 27-ны байдлаар нийт ААН-үүдээс газрын төлбөр 100,269,452 төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн.	
3.12	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх, сайжруулах дүгнэлт гарган ажиллах.	-	Байгууллагын дотоод хяналт шалгалтын тайлан.	Байгууллагын дотоод хяналт хийх ажлын төлөвлөгөөг баталж, өдөр тутмын үйл	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хийж, сайжруулах дүгнэлт гаргаж арга хэмжээ	1. Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан баталж, төлөвлөгөөний дагуу хяналт, шалгалтыг гүйцэтгэж байна. 2. Цаг тухай бүр шилэн дансыг шалгаж зөрүүтэй, дутуу оруулсан мэдээ мэдээллийг хугацаанд нь мэдээллэж ажилласнаар 2021 оны аудитын дүгнэлтээр зөрчилгүй дүгнэлт авсан. Мөн сангийн сайдын 2021 оны 10 сарын 29-ний 190 дугаар тушаалаар батлагдсан Зардлын эдийн засгийн	90

				ажиллагаа болон хэлтэс тус бүрийн ажлын гүйцэтгэлд хяналт хийн, чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн хувийн хэргийн бүрдүүлэлт, газар ашиглах, эзэмших гэрээ шинэчлэх хууль дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд тухай бүр үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан.	авах.	ангиллын дагуу төсвийн гүйцэтгэл, анхан шатны баримтад улирал тутам хяналтыг хийсэн. Албан хаагчдын тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хийгдсэн судалгааг гаргасан. 3. МУОК-ын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ний өдрийн 18 дугаар тушаалаар батлагдсан “Коронавируст халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ын хэрэгжилтийг хангуулах, АОК-ын 2022 оны 01 дугаар сарын 13-ны өдрийн 11 дүгээр албан тоотын дагуу чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа ААН-дэд халдвар хамгааллын дэглэмийг мөрдөн ажиллаж байгаатай холбогдуулан үүсч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Сүхбаатар боомт дахь хилийн мэргэжлийн хяналтын албаны Улсын ахлах байцаагчийн 2022 оны 01 сарын 19-ны 26-3-023/01 албан тоотоор зөвлөмж ирсэн. Энэхүү зөвлөмжийн дагуу халдвар хамгааллын дэглэм сахиулах хяналт шалгалтыг хийсэн. 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/01 тоот захирамжийн дагуу “Алтанбулаг” чөлөөт бүсэд 2022.01.14-2022.04.03-ны өдрүүдэд Улаанбаатар хотоос 19 албан хаагч ээлжээр хяналт хийж ажилласан. Үйл ажиллагаа явуулж байгаа ААН тус бүрт гэрээний үүргийг хангуулах тухай хугацаатай мэдэгдэл өгсөн. “Алтанбулаг” чөлөөт бүсрүү нэвтэрч буй зорчигчдын тоо ихсэж, ачаалал нэмэгдэж байгаатай холбогдуулан Гаалийн байгууллагатай уулзалт хийж, хамтран ажиллах санал солилцсон. 4. Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа 25-н ААН-үүдэд чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх гэрээ, Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн тохижилт, цэвэрлэгээний гэрээг дүгнэсэн.	
3.13	Чөлөөт бүсийн үйл ажиллагааг таниулах ажлын хүрээг тэлэх, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг	Төсөв суугда агүй. Өөрсд ийн дотоо д нөөц	www.altanbulag.gov.mn вебсайтын хөгжүүлэлт ийн тайлан.	Байгууллагын www.altanbulag.gov.mn вебсайтад чөлөөт бүсийн үйл	Чөлөөт бүсийн үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх ажил	1. 2022.09.10-ны өдөр Сүхбаатарын талбайд НҮБ, ЭЗХЯ-наас хамтран зохион байгуулсан “Тогтвортой хөгжлийн зорилго” нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож чөлөөт бүсийн үйл ажиллагааг сонирхохоор ирсэн иргэд, хөрөнгө оруулагчдад чөлөөт бүсийн талаар мэдээлэл өгч сурталчилгаа хийсэн. 2. www.altanbulag.gov.mn веб сайтад “Алтанбулаг”	100

	<p>зохион байгуулах, www.altanbulag.gov.mn веб сайтад байгууллагын талаарх мэдээ, мэдээллийг орос, англи, хятад хэл дээр орчуулан байршуулж олон нийтэд цаг тухайд нь хүргэх</p>	<p>болом жоор гүйцэт гэх.</p>	<p>Хамтын ажиллагааны гэрээ</p>	<p>ажиллагааны мэдээг тогтмол байршуулж, холбогдох байгууллага удтай хамтран ажилласан. www.altanbulag.gov.mn веб сайтад бүсийн талаарх мэдээ, мэдээллийг орос, англи, хятад хэл дээр хөрвүүлэн байршуулж олон нийтэд цаг тухайд нь хүргэн ажилласан. ОХУ-ын Эрхүү мужийн ажил хэргийн “Капиталист” сэтгүүлд нийтлэлд мэдээлэл бэлтгэж явуулсан. /2021 оны 09-10 сарын дугаар/</p>	<p>хийгдсэн байх.</p>	<p>чөлөөт бүсийн үйл ажиллагааны талаар нийт 88 багц мэдээ, бүсийн пэйж хуудаст 132 багц мэдээ, мэдээлэл бэлтгэж оруулсан бөгөөд шинээр “Алтанбулаг чөлөөт бүс” фейсбук хуудас үүсгэн хөгжүүлэлт хийн ажиллаж байна. Уг пэйж хуудаст чөлөөт бүсийг сурталчлан таниулах зорилгоор зарим улс орнуудын чөлөөт бүсүүдийн үйл ажиллагаа болон сайн туршлагын талаар хуваалцаж, чөлөөт бүсийн өнөөгийн байдал, бүсэд шинээр хийгдэж байгаа томоохон бүтээн байгуулалтууд болон байнгын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг сурталчлан танилцуулж байна.</p> <p>3. Бүсийн зорчигч тээврийн статистик мэдээг сар, улирлаар гаргаж веб сайт болон мэдээллийн самбарт байршуулж олон нийтэд хүргэхээс гадна олон нийтийн мэдээллийн сайтууд болон фейсбук хуудасны мэдээ, мэдээллүүдэд тогтмол анализ хийж эерэг мэдээллүүдийг “Алтанбулаг” чөлөөт бүсийн цахим хаяг болон фейсбук групп, пэйж хуудаст шейр хийн түгээж байна.</p> <p>4. “Алтанбулаг” чөлөөт бүсийн видео танилцуулгыг шинэчлэн хийх эх бэлтгэлийн ажил дууссан ч санхүүжилт байхгүйн улмаас түр хойшилсон. Мөн 2022 оны зорчигч тээвэр, бараа эргэлтийн мэдээний нэгдсэн статистик мэдээг видео танилцуулгад засварлаж оруулахаар шторк хийсэн студитэй тохиролцсон.</p>	
--	---	-------------------------------	---------------------------------	---	-----------------------	---	--

3.14	Сүлжээний аюулгүй байдлыг ханган ажиллах. Компьютер, түүний дагалдах хэрэгслийн засвар үйлчилгээг хийх.	2,060,100 төгрөг. /Мэдэ элэл, технологийн зардал/	Байгууллагын мэдээллийн технологи, мэдээллийн сүлжээний найдвартай ажиллагааг хангах, технологийн үйл ажиллагааг хөгжүүлэх, кибер халдлагаас хамгаалах	- Албан хаагчдын компьютерын хүчин чадлын, тоног төхөөрөмжийн судалгааг хийж, дотоод сүлжээний найдвартай ажиллагааг хангах, дагалдах хэрэгслийн засвар үйлчилгээг тогтмол хийн ажиллаж байна. - Гаалийн байгууллагын теле хяналтын "GENETIC" системд холбуулах, гаалийн нэгдсэн сүлжээнд холбогдох ажлын хүрээнд "Арш технологи" ХХК-аар зургийн	Техник технологи, дотоод сүлжээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангах, кибер халдлагаас хамгаалах. Сүлжээний аюулгүй байдлыг хангах ажиллах. Компьютер болон түүний дагалдах хэрэгслийн засвар, үйлчилгээг тухай бүр хангасан байх.	<ol style="list-style-type: none"> 1. Албан хаагчдын компьютерийн хүчин чадлын судалгааг хийж шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг шинэчилэн сольсон. Мөн байгууллагын интернетийн хурдыг сайжруулах талаар судалж интернет дамжуулах /switch/ төхөөрөмжийг шинэчлэн суурилуулсан. 2. Дотоод сүлжээний найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна. Байгууллагын албан хаагчдын компьютерт "ESET NOD32" антивирусын программ суулган гүйцэтгэсэн. Албаны цахим шуудангийн админ эрхийг шилжүүлэн авч, албан хаагчдын мэйл хаягуудын нууц үгийг шинэчлэн нээж өгөв. 3. Гаалийн байгууллагын теле хяналтын "GENETIC" системд холбуулах, гаалийн нэгдсэн сүлжээнд холбогдох ажлын хүрээнд "Арш технологи" ХХК-тай холбогдож одоогийн шийдэл, үнийн шинэчлэл, дэд бүтцийн талаар зөвлөлдөж судалгааг дахин хийж нягталж үнийн саналаа шинэчилж хүргүүлсэн бөгөөд нийт 553,900 төгрөгийг төсөвт суулгуулсан. 4. Төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд : <ul style="list-style-type: none"> - "ХУР" системийг нэвтрүүлэх хүсэлт, мэдээллийн жагсаалтыг, системд холбогдох хандах гадаад IP хаяг, Байгууллагын нэр, Encrypted.asc файлыг татаж аван текстээр задлаад түлхүүрийг хуулах, мөн mailvelope extension -ы decrypt цэсний текст хэсэгт хуулсан түлхүүрийг оруулсан. - "OpenVPN" хэрэглэгчийн програмыг татаж суулгаж тохиргоо хийгдсэн. - Эцсийн шатанд системд нэвтрэлтийн тухайд Виртуал серверт холбогдох талаар хүсэлтийг хүргүүлээд байна.Гаалийн деклораци олголтыг хялбаршуулах, цахимжуулах талаар дараах ажлуудыг хийлээ.Үүнд: <ul style="list-style-type: none"> - Шалган нэвтрүүлэхийн программыг гаалийн CAIS программтай холбож, туршилт тохируулгын ажлыг "Гэрэгэ системс" ХХК, "Аствишн"ХХК-иуд хийгээд байна. 5. ГЕГ-ын МТТ-өөс шалган нэвтрүүлэхийн программаас сервер татах, дэлгүүрүүдийг холбох тухайд ажлын хэсэг гарч газар дээр нь ажиллаж эцэслэн шийдэхээр боллоо. 5. Хамтран ажиллаж буй байгууллагуудтай 3 удаагийн зөвлөлдөх уулзалтуудыг хийж, эцсийн байдлаар ГЕГ-аас тодорхой шийдлийг хүлээж байгаа болно. 	95
------	---	---	--	--	--	---	----

				даалгавар хийлгэсэн. -“ХУР” төрийн мэдээлэл солилцооны системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд Үндэсний дата төвтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан.		6. “Алтанбулаг” чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд бүртгүүлэх, бүртгэлийн гэрчилгээг авах үйлчилгээний үндсэн зарчим болон нэвтрэлтийн талаар “E-Mongolia Академитай ажиллаж, тус чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ авах үйлчилгээг E-Mongolia системээр мэдүүлж авахаар болов.	
Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт							
4.1	“Алтанбулаг” чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах. Орон нутагт ажлын талбайг гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх	-	Гэрээ. Ажил хүлээлцэх акт.	“Алтанбулаг” чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн түр шугам.	“Алтанбулаг” чөлөөт бүсийн болон Алтанбулаг сумын цахилгаан хангамжийн хүчин чадал нэмэгдэнэ.	“Алтанбулаг” чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөлийн ажил 35\10 кВ-ын 2*4000 кВа чадал бүхий дэд станцын барилга угсралтын ажил, 10кв-н хуваарилах байгууламж, 2*630 кВа чадалтай хаалттай дэд өртөөний барилга угсралтын ажил гүйцэтгэж буй “Улаанбаатар электро монтаж” ХХК болон Эдийн засаг, хөгжлийн яам хооронд ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан.	100
4.2	“Алтанбулаг” чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллах.	2,000,000 төгрөгийн төсөв шаардлагатай.	Захиалагчийн хяналт тавьсан баримт бичиг.	Сэлэнгэ Алтанбулагийн 25 км бохир усны шугам хоолойн цахилгаан хангамжийн ажил.	“Алтанбулаг” чөлөөт бүсийн болон Алтанбулаг сумын цахилгаан хангамжийн хүчин чадал нэмэгдэнэ.	Бүсийн 35/10 кВ-ын цахилгааны өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэх “Улаанбаатар электро монтаж” ХХК, барилгын туслан гүйцэтгэгч “Түшигт хангай” ХХК-д 35 станц барих газрыг үзүүлж танилцуулсан. “Алтанбулаг” чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөлийн ажил 35/10 кВ 2х4000 кВа дэд станцын барилга угсралтын ажил, 10кв-н хуваарилах байгууламж, 2х630 кВа чадалтай хаалттай дэд өртөөний барилга угсралтын ажил гүйцэтгэж буй “Улаанбаатар электро монтаж” ХХК-тай холбоотой баримт бичиг Эдийн засгийн хөгжлийн яам, Эрчим хүчний үндэсний төв гаргаж өгсөн. Захиалагчийн хяналтын гэрээ хүргүүлсэн.	95

4.3	БНСУ-ын Котра байгууллага болон Зам тээврийн яамтай чөлөөт бүсийн логистикийн ТЭЗҮ болон зураг төсөл дээр хамтран ажиллах.	-	Зураг төсөл.	“Нью урбанизм” ХХК-ийн хийсэн судалгаа.	“Алтанбулаг” чөлөөт бүсэд логистикийн бүс байгуулагдах эхлэл тавигдана.	2022 оны 2 дугаар сарын 15-18-ны хооронд Котрагын зөвлөх компанийн Гүйцэтгэх захирал LEE Sangchul, инженер JO Hanna болон ЗТЯ-ны холбогдох хүмүүс чөлөөт бүс болон боомтод ажиллаж чөлөөт бүсэд барих логистикийн бүсийн талбай болон чөлөөт бүсийн дэд бүтцийн барилга байгууламжтай танилцсан. Төслийн хүрээнд Зам тээвэр, хөгжлийн яамнаас 01/166 тоот албан бичиг ирүүлсний дагуу чөлөөт бүсийн тээвэр логистикийн бүсэд газар эзэмшигч аж ахуй нэгжийн газрыг чөлөөлөх саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. “Чөлөөт бүсийг хөгжүүлэх” төслийн тайлант хурал 2022.11.03-ны өдөр Эдийн засаг хөгжлийн яаманд амжилттай зохион байгуулагдсан.	100
4.4	2023 оны төсвийн тухай хуульд “Алтанбулаг” чөлөөт бүсэд хийгдэх дэд бүтцийн ажлын талаар санал боловсруулж төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.	-	Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн дэд бүтцийн ажлын санал.	Жил бүрийн төсвийн тухай хуульд “Алтанбулаг” чөлөөт бүсэд хийгдэх дэд бүтцийн ажлын талаар санал боловсруулж төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлдэг.	2023 оны төсвийн тухай хуульд “Алтанбулаг” чөлөөт бүсэд хийгдэх дэд бүтцийн ажлыг тусгасан байна.	1. “Алтанбулаг” чөлөөт бүсийн цэвэр ус хангамжийн дэд бүтцийг хэсэгчилсэн байдлаар ашиглалтад оруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Алтанбулаг чөлөөт бүсийн дулаан хангамжийг бие даасан байдлаар шийдвэрлэхээр техник эдийн засгийн үзүүлэлтийг боловсруулж байна. 2. “КОМФОРТ ИМПЕКС” ХХК цэвэр усны шугам сүлжээ ашиглалтад орох үед тоног төхөөрөмжүүдийг суурилуулж, тохиргоо туршилт хийж байгаа. Ажлын гүйцэтгэлийн тайлан авахаар албан бичиг хүргүүлсэн. 3. “Жишиг сум” төсөл арга хэмжээний хүрээнд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах зургийн даалгавар шинэчлэхтэй холбоотой Алтанбулаг сумын бохир усны шугамын шинэчлэлтийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт Алтанбулаг чөлөөт бүсээс сумын цэвэрлэх байгууламж хүртэлх сумын төвийг дайран өнгөрч буй манай эзэмшлийн бохирын шугамын трасс давхцуулахгүй байх мөн бүсийн бохир усны шугамыг Алтанбулаг сумын цэвэрлэх байгууламжид холбогдохоор тусгуулахаар Сэлэнгэ аймгийн Ерөнхий төлөвлөгөөний хэлтэст санал хүргүүлсэн. 4. “Жишиг сум” төсөл арга хэмжээний хүрээнд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах зургийн даалгавар шинэчлэхтэй холбоотой	100

						Алтанбулаг сум, “Алтанбулаг” чөлөөт бүс, боомт нэгдсэн байдлаар дулаан хангамж шийдвэрлүүлэхээр Сэлэнгэ аймгийн засаг даргын тамгын газар, Хөгжлийн бодлого, Төлөвлөлт, Хөрөнгө оруулалтын хэлтэст албан бичгээр хүргүүлсэн.	
4.5	“Алтанбулаг” чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөөний ажил.	-	“Алтанбулаг” чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөө.	“Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөө, мастер төлөвлөгөө.	“Алтанбулаг” чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөө 100% хийгдсэн байна.	1. “Алтанбулаг” чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөөнд тавигдах архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулан ГЗБГЗЗГ хүргүүлж мэргэжлийн байгууллагуудаас санал авч БХБЯ-нд хүргүүлсэн. Төслийг БХБЯ-ны сайдын багцаас санхүүжүүлж хийхээр тендер нь зарлагдан гүйцэтгэгч компани шалгарсан байна. 2. “Идеал групп” ХХК-ийн гүйцэтгэж буй “Алтанбулаг” чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөө шинэчлэн боловсруулж байгаатай холбоотой хамтран ажиллах хүсэлтийн дагуу улсын төсөвт суусан инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийн тогтоол, тушаал, холбогдох зурагт төсөл холбогдох материалыг бүрдүүлж өгсөн. 3. “Идеал групп” ХХК-с гаргасан ерөнхий төлөвлөгөө боловсруулахтай холбоотой барилга байгууламж, батлагдсан зураг төсөл холбогдох мэдээлэл, санал хүсэлтийг аж ахуй нэгжүүдээс авсан.	97
4.6	Цахилгаан хангамжийн дэд өртөөнүүд, цахилгаан дамжуулах агаарын шугамуудад тогтмол үзлэг хийж, үзлэгээр илэрсэн зөрчлийг цаг тухайд нь арилгаж ажиллах.	Шатах ууны зардал: 250.000 төгрөг	Ажлын тайлан.	Жил бүр тогтмол хийгддэг ажил.	Цахилгаан хангамжийн дэд өртөөнүүд, цахилгаан дамжуулах агаарын шугамуудад тогтмол үзлэг хийнэ. Үзлэгээр илэрсэн зөрчлийг цаг тухайд нь арилгаж ажиллана.	1. 2022 оны 03 сарын 09-ны өдөр хүчтэй салхины улмаас КТП-424-ийн өндрийн хуурай салгуурын гарны холбогч боолт унасны улмаас буултын утасны А,В фазын хооронд наалдаж газардлага үүсгэснийг засварлаж гэмтлийг устгаж шугамыг хүчдэлд залгасан. 2. 2022 оны 03-р сарын 16-ны өдөр бүсийн 6 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамд газар шорооны ажил гүйцэтгэж байсан экскаватор гэмтэл гаргасныг “ДСЦТС” ХХК-ний ажилчдын хамт гэмтлийг устгаж шугамыг хүчдэлд залгасан. 3. Дээрхи гэмтлүүд гарч шугам хүчдэлгүй болсон үед шугамын трасст үзлэг хийж КТП-405, 424-ийн цэнэг-2022 оны 03 сарын 09-ны өдөр хүчтэй салхины улмаас КТП-424-ийн өндрийн хуурай салгуурын гарны холбогч боолт унасны улмаас буултын утасны А,В фазын хооронд наалдаж газардлага үүсгэснийг засварлаж гэмтлийг устгаж шугамыг хүчдэлд залгасан. 4. Дээрхи гэмтлүүд гарч шугам хүчдэлгүй болсон үед	98

						<p>шугамын трасст үзлэг хийж КТП-405, 424-ийн цэнэг шавхагч, өндрийн гал хамгаалагч, 0.4 кВ-ын ерөнхий автомат, ААН-дийн хувиарлах шитний ерөнхий автоматуудад чангалгаа хийсэн.</p> <p>5. КТП 405-н 0,4 кВ-ын хувиарлах щитний таслаж залгах рубельникийн В фаз, С фазад халалт үүсч дахин ашиглах боломжгүй болсон тул шинээр сольж суурилуулсан.</p> <p>6. “Хаан ертөнц чөлөөт бүс” ХХК, “Өсөх буудай чөлөөт бүс” ХХК-ний тэжээлийн кабель “Силк роуд чөлөөт бүс” ХХК-ний барилгийн сууринд таарсан тул шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>7. “НКВ интернэшнл холдинг” ХХК нь газар шорооны ажил гүйцэтгэх явцдаа бүсийн Сүхбаатар-Алтанбулагийн 25 км БУНС-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур №3-ын төмөр бетон тулгуурыг мөргөж унагааж, дагалдах тоноглолыг гэмтээсэнийг акт үйлдэж тухайн ААН-ээр хохирлыг барагдуулж, уг ажлыг “ДСЦТС” ХХК-ний ажилчдаар хийж гүйцэтгүүлж хэвийн байдалд оруулсан.</p> <p>8. Хүчдэлд залгуулахын тулд шугамын үзлэг хийж дараах гэмтлүүдийг устгасан.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 1 дүгээр станцын тулгуур баганыг татаж тэгшилсэн. - ЦДАШ-ын тулгуур №28, 29, 31-ын дамжуулагч утас засварласан. - ЦДАШ-ын тулгуур №98, 89, 90, 91,92 намагны улмаас хазайсныг татаж тэгшилж, чулуугаар чигжээс хийсэн. - 6 дугаар станцын цэнэг шавхагч аянгын улмаас буудсаныг шинээр сольж засварласан. - 1-7 дугаар станцын 0.4 кВ-ын хуваарилах самбарт шувуу үүрлэснийг устгаж цэвэрлэсэн. 	
4.7	Бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгжүүдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах. Заавар зөвлөмж тогтмол өгч байх.	Бичиг хэрэг болон бусад зардал: 50.000 төгрөг.	Хяналт, үзлэгийн тэмдэглэл.	Жил бүр тогтмол хийгддэг ажил.	Аж ахуй нэгжүүдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ, аюулгүй байдалд хяналт тавигдаж, ХХАА-ны	<p>1. ЗАА-ны байр,Гаалийн түр байрнуудын халаалтын тогоо, цахилгаан халаагууруудыг дулааны улиралд багасгаж эрчим хүчний хэмнэлт хийж ажиллаж байна.</p> <p>2. Бүсэд үйл ажиллагаа эрхэлж буй цахилгаан эрчим хүчний төлбөрийн үлдэгдэлтэй ААН-үүдийн тооцоог шахаж хийлгэж үлдэгдлийг багасгасан.</p> <p>3. Дээрхи хугацаанд тоолуур баталгаажуулалт нь дууссан 7 ААН-ийг “ДСЦТС” ХХК-ний тоолуур хэмжих хэрэгслийн лаборатороор оруулж баталгаажуулан буцааж суурилуулах ажлыг гүйцэтгэсэн.</p>	98

					дэвтэрт гарын үсэг зурагдсан байна.	<p>4. Бүсэд барилга байгууламж барьж буй ААН-үүдэд түр болон байнгын цахилгааны эх үүсвэрт холбохдоо аюулгүй ажиллах зааварчилгаа өгч байна.</p> <p>5. Бүсийн түр цахилгаан хангамжийн КТП-424-ийн ерөнхий тоолуур ашиглалтын стандартаас гарсаныг шинэ тоолуур тавьж суурилуулж “ДСЦТС” ХХК-ний лаборатороор хянуулж баталгаажуулсан.</p> <p>6. Дараах тооцоо судалгааг боловсруулсан.</p> <ul style="list-style-type: none"> - ХТП-521-ийн “ДСЦТС” ХХК-ний Дарханаас туршилт тохируулгын ажил хийх өндрийн явуулын лаборатори ирүүлэх үнийн судалгаа, мөн худалдан авах шаардлагатай тоноглолын тооцоо - Худалдаа үйлчилгээний 3 дугаар талбайн ААН-үүдийг цахилгаан эрчим хүчээр хангах шит ба дагалдах шугам тоноглол, тэжээлийн кабель бусад шаардлагатай материалын тооцоо - 2023 онд төсөвт суулгах шаардлагатай багаж хэрэгсэл, материалын тооцоо - Гаалийн өрөөнд хийгдэх засварын тооцоо - Бүсийн харуул хамгаалалтын хашааны гэрэлтүүлэг, 1-10, 10-9 цэгийг цахилгаан эрчим хүчтэй болгоход шаардлагатай материалын тооцоо - Бүсийн худалдаа, үйлчилгээний зам талбайн гэрэлтүүлэг хийхэд шаардлагатай материалын тооцоо - Бүсийн худалдаа үйлчилгээний зам талбайн камержуулалтанд шаардлагатай материалын тооцоо боловсруулсан. 	
4.8	“ДСЦТС” ХХК-ийн Сүхбаатар салбартай эрчим хүч нийлүүлэх гэрээ байгуулах, цахилгаан эрчим хүчний тоолуурын заалтыг тогтмол хүргүүлэх.	Бичиг хэргийн зардал: 25.000 төгрөг.	Эрчим хүч нийлүүлэх гэрээ, тоолуурын заалтын баримт.	Жил бүр тогтмол хийгддэг ажил.	“ДСЦТС” ХХК-ийн Сүхбаатар салбартай эрчим хүч нийлүүлэх гэрээ байгуулж, цахилгаан эрчим хүчний тоолуурын заалтыг сар бүр авч хүргүүлсэн	“ДСЦТС” ХХК-ийн Сүхбаатар салбартай эрчим хүч нийлүүлэх гэрээ байгуулсан. Гэрээний дагуу тоолуурын заалтыг тогтмол хүргүүлж байна.	100

					байна.		
4.9	“Алтанбулаг” чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн барилгын эскиз зурагт тавигдах шаардлага, барилгын норм ба дүрмийн дагуу боловсруулсан эсэхэд хяналт тавьж ажиллах. Мэргэжлийн талаас заавар зөвлөмж өгөх.	Бичиг хэргийн зардал: 50.000 төгрөг	Барилга байгууламжийн батлагдсан эскиз зураг.	Жил бүр тогтмол хийгддэг ажил.	Бүсэд баригдаж байгаа барилга байгууламжид “Барилгын тухай” хуулийн дагуу тухай бүр хяналт тавьж ажиллах	1. “Алтанбулаг” чөлөөт бүсийн Худалдаа үйлчилгээний 6.2 га зам талбайд баригдсан аж ахуйн нэгжүүдийн барилга байгууламжийн загвар дизайныг бүсийн өнгө үзэмж, хөгжлийн ирээдүй талаас бодож жигдрүүлэх талаар эскиз зураг гаргав. 2. “Алтанбулаг” чөлөөт бүсийн худалдаа үйлчилгээний зам талбайн камержуулалт, гэрэлтүүлгийн зураглал, тооцоо судалгааг боловсруулсан. 3. “Алтанбулаг” чөлөөт бүсийн худалдаа үйлчилгээний зам талбайн гэрэлтүүлгийн зураглал, тооцоо судалгааг боловсруулсан. 4. “Алтанбулаг” чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч “Минзано чөлөөт бүс” ХХК, “Алтанбулаг ирээдүй чөлөөт бүс” ХХК-ын эскиз зураг баталж, Архитектур төлөвлөлтийн даалгавар, дэвсгэр зураг хүргүүлсэн. 5. Бүсэд барилгын ажил явуулж байгаа ААН-үүдээс идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа Итирнатитур ЧБ ХХК, Монродиум ЧБ ХХК, Нэг бүс нэг зам нэг зорилго ЧБ ХХК, Хаан тэс ЧБ ХХК, Элээт ЧБ ХХК, Силкроуд интернейшнл ЧБ ХХК, Алтанбилиг ЧБ ХХК, ААН-үүдийн үйл ажиллагаанд хуваариар хяналт тавьж, ХАБЭА-н зааварчилгаа өгч байна.	98
4.10	“Алтанбулаг” чөлөөт бүсэд газар эзэмшиж буй Аж ахуйн нэгжүүдийн барилга угсралтын ажилд барилгын норм дүрмийн дагуу хяналт тавих, БУА эхлүүлэх үргэлжлүүлэхэд бүрдүүлэх бичиг баримтыг бүрдүүлэх.	Бичиг хэргийн зардал: 50.000 төгрөг	ААН-ийн барилга угсралтын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх бүрдүүлэх бичиг баримт, барилга угсралтын ажилд барилгын норм дүрмийн	Жил бүр тогтмол хийгддэг ажил.	“Алтанбулаг” чөлөөт бүсэд газар эзэмшиж буй Аж ахуйн нэгжүүдийн БУА эхлүүлэх үргэлжлүүлэх бүрдүүлэх бичиг баримтыг бүрдүүлж, барилга угсралтын ажилд барилгын норм дүрмийн дагуу хяналт тавьж	1. “Алтанбулаг” чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч “Итирнатитур чөлөөт бүс” ХХК, “Элээт чөлөөт бүс” ХХК, Монродиум чөлөөт бүс” ХХК, “Хүчит безон чөлөөт бүс” ХХК-дын барилгын зураг төсөлд барилгын норм ба дүрэм, тавигдах шаардлагын дагуу заавар зөвлөмж өгсөн. 2. 2022.05.05-нд Магнет дэлгүүрийн гадна пасадны хөөсөн үе хөндийрсөн хэсгүүдэд үзлэг хийсэн. 3. “Алтанбулаг” чөлөөт бүсэд барилга байгууламж баригдсан, үйл ажиллагаа явуулж буй “Тинатин чөлөөт бүс” ХХК, “Глобал бридж чөлөөт бүс” ХХК, “Халиун уул чөлөөт бүс” ХХК, “Голомт бадрах чөлөөт бүс” ХХК гэх мэт аж ахуйн нэгжүүдийн барилгад засвар үйлчилгээ хийгдэх хэсэгт компаний төлөөллүүдэд хэлж барилгын ажил эхлэх хугацаанд буюу дулааны улиралд гүйцэтгэх зөвлөмж өгсөн. 4. “Алтанбулаг” чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч “Итирнатитур чөлөөт бүс” ХХК, “Монродиум чөлөөт бүс” ХХК,	97

			дагуу хяналт тавьсан тухай тайлан баримт.		барилга угсралтын ажлыг явуулах.	<p>“Жасу ба ой чөлөөт бүс” ХХК, “Сэлэнгэ чандмань чөлөөт бүс” ХХК-дад мэргэжлийн талаас заавар зөвлөмж өгч цаашид барилга барихад шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх материалуудыг өгч чөлөөт бүсийн дэвсгэр зураг болон Архитектур төлөвлөлтийн даалгавруудыг өгөв.</p> <p>5. “Алтанбулаг” чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч “Гурван мэргэд чөлөөт бүс” ХХК-ны түр барилгад хяналт тавьж мэргэжлийн талаас заавар зөвлөмж өгч ажилласан.</p> <p>6. Алтанбулаг” чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч “Итирнатитур чөлөөт бүс” ХХК нь худалдаа үйлчилгээний барилга байгууламжийн угсралтын ажил дуусч улсын комисс ажиллав.</p>	
4.11	Цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усны шугамд холбогдохыг хүссэн, бүсэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид техникийн түр нөхцөл олгож, холболт хийлгэх, холболтын ажилд хяналт тавьж ажиллах.	Бичиг хэргийн зардал: 50.000 төгрөг	Техникийн нөхцөл.	Жил бүр тогтмол хийгддэг ажил.	Цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усны шугамд холбогдохыг хүссэн бүсэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид техникийн нөхцөл олгож, холболт хийлгэн, холболтын ажилд хяналт тавьж ажиллах.	<p>1. “Элээт, Монродиум чөлөөт бүс” ХХК, “Минзона чөлөөт бүс” ХХК, “Хаан тэс чөлөөт бүс” ХХК-дад техникийн нөхцөл олгосон, “Итернатитур, Хүчит безон” ХХК-ниудад тодруулга хуудас өгсөн.</p> <p>2. “Нэг бүс, нэг зам, нэг зорилго чөлөөт бүс” , “Хаан тэс чөлөөт бүс” ХХК-ниудыг техникийн нөхцлийн дагуу цахилгаан эрчим хүчинд холбосон.</p> <p>3. КТП-424-ийн 0.4 кВ-ын хувиарлах шитийг шинээр монтажлаж аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын дүрмийн дагуу шитийг тоноглож, 11 ААН-ийг уг хуваарилах самбарт холбосон.</p> <p>4. “Элээт чөлөөт бүс” ХХК нь барилгийн ажлаа хийж гүйцэтгэж эхэлсэн тул 220В-ын түр цахилгаанаар хангасан.</p> <p>5. Цэвэр усны 7 худгийн 6 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур №24-өөс Алтанбулаг боомтын авто замын ажил гүйцэтгэж буй “НКВ International Holding Co.Ltd. нь салбарлан авч 2022 оны 06 дугаар сарын 6-ны өдөр “ДСЦТС” ХХК-р шалгуулан хүчдэлд холбосон.</p> <p>6. “Монгол алтай индастри” чөлөөт бүс ХХК баригдаж байгаа цэвэр, бохирын шугам холбох техникийн хүсэлтийн дагуу гаргаж өгсөн.</p> <p>7. “Юнайтед шиппинг” ХХК чөлөөт бүс ХХК Алтанбулаг чөлөөт бүсэд Тээвэр, Логистик зориулалт бүхий 2га газар, Агуулах зориулалт бүхий 1га газарт цэвэр, бохирын шугам холбох техникийн хүсэлтийн дагуу гаргаж өгсөн.</p> <p>8. “Хан судар” чөлөөт бүс ХХК Агуулахын зориулалттай 2га газар барилгад цэвэр, бохирын шугам холбох техникийн</p>	99

						хүсэлтийн дагуу гаргахад бэлдсэн. Төлбөрийн асуудлаас үүдэж техник нөхцөл олгох хүлээгдэж байна. 9. “Эко иннива винд”, “Люксвүүд продукт” чөлөөт бүс ХХК ХХК худалдаа үйлчилгээний бүсэд, “Бум буянт од” ХХК худалдаа үйлчилгээний бүсэд 400м2 газарт цэвэр, бохирын шугам холбох хүсэлтийн дагуу тс тус техникийн нөхцөл олгосон.	
4.12	Кадастр хийх, кадастрын зураглал гаргах компанитай хамтран ажиллах гэрээг дүгнэж сунгах.	Бичиг хэргийн зардал: 20.000 төгрөг	Ажлын гэрээ.	Жил бүр тогтмол хийгддэг ажил.	Кадастр хийх, кадастрын зураглал гаргах компанитай хамтран ажиллах гэрээг дүгнэж, гэрээ сунгагдсан байна.	Хамтран ажиллах гэрээг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр баталгаажуулсан.	99
4.13	2022 оны газар олголтын төлөвлөгөөг батлах, дуудлага худалдаагаар иргэн аж ахуйн нэгж байгууллагуудад газар ашиглуулах ажлыг 2 хүртэл удаа зохион байгуулах.	Бичиг хэргийн зардал.	2022 оны газар олголтын төлөвлөгөө. Газрын дуудлага худалдаа зохион байгуулсан тайлан.	2022 онд шинээр хийгдэх ажил	Дуудлага худалдаагаар газар ашиглуулах ажлыг зохион байгуулж, газар эзэмшигч ашиглагчтай гэрээ байгуулах.	Эдийн засаг, хөгжийн яамнаас газар олголт түр хугацаанд хийхгүй байх тухай албан бичиг ирсэн бөгөөд мөн чөлөөт бүсийг нэгдсэн цогцолбор байдлаар кластержуулан хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж байгаатай холбоотойгоор газар чөлөөлөлтийн ажил хийгдэхээр төлөвлөж байна. Иймд газар олголтын төлөвлөгөөг батлуулаагүй болно.	100
4.14	Газрын харилцаа, геодези зураг зүйн газартай хамтран кадастрын мэдээллийн сангийн “Ленд-менежер программын нэмэлт хөгжүүлэлтийн дагуу ажил үүрэгтээ нэвтрүүлж ажиллах.	Бичиг хэргийн зардал: 80.000 төгрөг	Газрын харилцаа, геодези зураг зүйн газартай хамтран кадастрын мэдээллийн сангийн “Ленд-менежер программ.	“Ленд-менежер программийг 2019 оноос үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа	ГХГЗЗГ-тай хамтран кадастрын мэдээллийн сангийн “Ленд-менежер программыг нэвтрүүлж программын нэмэлт хөгжүүлэлтийг ажил үүрэгтээ	Газрын асуудал хариуцсан мэргэжилтэн шинээр томилогдсонтой холбоотойгоор газрын нэгдсэн мэдээллийн санд нэвтрэх эрхийг олгох хүсэлтийг Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газарт албан бичгээр гаргасан бөгөөд 2022 оны 03 дугаар сарын 29-ны өдөр Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын даргын тушаалаар эрхийг нээсэн. Газрын харилцаа, геодези зураг зүйн газартай тухай бүрт холбогдож Ленд-менежер программын нэмэлт хөгжүүлэлтийн дагуу ажил үүрэг гүйцэтгэж байна.	100

					нэвтрүүлж ажиллана.		
4.15	“Алтанбулаг” чөлөөт бүсэд газар эзэмшиж байгаа болон шинээр газар эзэмшиж, ашиглах аж ахуйн нэгж байгууллагуудад нэгж талбарын эргэлтийн цэгийг газарт бэхлүүлэх мэдэгдэл өгч кадастрын зургийг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар гаргуулж мэдээллийн санд оруулах.	Бичиг хэргийн зардал: 100.000 төгрөг	Аж ахуйн нэгж байгууллагын нэгж талбарын эргэлтийн цэгийг газарт бэхлүүлсэн мэдэгдэл, кадастрын зураг.	Жил бүр тогтмол хийгддэг ажил.	Кадастрын зургийг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар гаргуулж мэдээллийн санд тухай нь оруулсан байна.	-Тайлант хугацаанд: -5 нэгж талбарын газар эзэмших эрхийг хүчингүй болгох захирамж гарсан бөгөөд холбогдох захирамжийг газрын нэгдсэн мэдээллийн санд оруулсан. -Газар эзэмших эрхийн гэрчилгээг гээж үрэгдүүлсэн 2 нэгж талбарын гэрчилгээг нөхөн олгосон бөгөөд цахим гэрээ, гэрчилгээг үүсгэн аж ахуй нэгжид нь мэдэгдсэн. -Газрын төлбөрийг барагдуулсан бөгөөд газрын гэрчилгээг нөхөн авах хүсэлт ирүүлсэн 2 аж ахуй нэгжийн газрын гэрчилгээг нөхөн бүрдүүлэлтээр олгосон. -Газар эзэмших эрх бүхий 3 аж ахуй нэгж нь газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1-т заасны дагуу газрын эрхийг шилжүүлсэн бөгөөд холбогдох баримт бичгийн бүрдлийг ханган газрын нэгдсэн мэдээллийн санд бүртгэж, гэрээ гэрчилгээг олгосон. - Шүүхийн шийдвэрийн дагуу Газрын төлбөрийг барагдуулан тооцоо дуусгаж, газар эзэмших эрхийг сэргээх хүсэлт ирүүлсэн 1 аж ахуй нэгжийн газар эзэмших эрхийг сэргээсэн бөгөөд холбогдох захирамжийн дагуу газрын нэгдсэн мэдээллийн санд бүртгэсэн.	100
4.16	“Алтанбулаг” чөлөөт бүсэд газар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд эзэмшлийн газартаа хашаа болон барилга барихад кадастрын эргэлтийн цэгүүдийг зааж өгөх, хяналт тавьж ажиллах.	Бичиг хэргийн зардал: 50.000 төгрөг	“Алтанбулаг” чөлөөт бүсэд газар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгж байгууллаг уудад хяналт тавьж ажиллах.	Жил бүр тогтмол хийгддэг ажил.	“Алтанбулаг” чөлөөт бүсэд газар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад кадастрын эргэлтийн цэгүүдийг зааж өгч, хяналт тавьж ажилласан байна.	1. “Таван хан технологи”ХХК нь газар дээрх үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг гаргуулахаар хүсэлт ирүүлсэний дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт барилгын талаарх мэдээллийг албан бичгээр хүргүүлсэн бөгөөд барилгын координатыг газрын мэдээллийн нэгдсэн санд оруулсан. 2. “Итирнатитур”ХХК нь газар дээрх үл хөдлөх хөрөнгийн эргэлтийн цэгийг нэгдсэн мэдээллийн санд оруулах хүсэлт ирүүлсэний дагуу барилгын координатыг газрын мэдээллийн нэгдсэн санд оруулж холбогдох материалыг тус компанид хүргүүлсэн болно. 3. “Алтанбулаг” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны эзэмшлийн нийт 13 газраас чөлөөт бүсэд байрлах 10 нэгж талбар байна. Үүнээс нэгж талбарын зөрчилгүй 6 нэгж талбарын кадастрыг Газрын нэгдсэн мэдээллийн системд оруулж цахим гэрээ гэрчилгээ үүсгэсэн. Үлдсэн 4 нэгж талбарын кадастр нь зөрчилтэй тул холбогдох аж ахуй нэгж	98

						болон дээд шатны байгууллагад хандан шийдвэрлүүлэхээр хүсэлт хүргүүлээд байна.	
4.17	Чөлөөт бүсийн тухай хууль, Газрын тухай багц хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан өөрчлөлтийн талаар танилцуулга материал бэлтгэх.	Бичиг хэргийн зардал: 100.000 төг	Танилцуулгын материал.	Жил бүр тогтмол хийгддэг ажил.	Танилцуулга материал бэлтгэж иргэд аж ахуйн нэгжийг мэдээллээр хангах, байгууллагын веб сайтад байршуулах.	Эдийн засаг, хөгжлийн яамд хэлэлцүүлэгдсэн Чөлөөт бүсэд мөрдөгдөх журмын төсөлд тусгагдах газрын харилцааны зохицуулалтад газар ашиглагчийн эрх, үүргийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй газрын тухай хуулийн газар эзэмшигчийн эрх үүргийн дагуу дүйцүүлж саналыг хүргүүлсэн. Тус журмын төсөл эцэслэн батлагдсаны дараа газрын харилцааны зохицуулалтын талаар танилцуулга бэлтгэн аж ахуй нэгжид хүргүүлнэ.	95
4.18	Чөлөөт бүсийн зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа эргэлтийн мэдээг сар, улирал, жилээр гаргах, чөлөөт бүсэд нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл хийх	1,617,500 төгрөг /Улсын маягт хэвлүүлэх зардал/	Зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа эргэлтийн мэдээ, тайлан.	2021 онд нийт зорчигч - 202206 , дотоод зорчигч - 202157 , гадаад зорчигч - 49 , нийт тээврийн хэрэгсэл - 43032 , дотоод тээвэр - 43010 , гадаад тээвэр - 22 нэвтэрсэн. Бараа эргэлт нийт орсон бараа - 11,872,883.42 ам доллар , борлуулсан	Зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа эргэлтийн мэдээ тайланг тухай бүр гаргасан байна.	1. 2022 оны 11-р сарын 21-ний өдрийг дуустал бүсээр нэвтэрсэн хөдөлгөөн: Нийт зорчигч 388,472 ; - Дотоод зорчигч 387 729 , - Гадаад зорчигч 743 , Нийт тээврийн хэрэгсэл 83,107 ; - Дотоод тээврийн хэрэгсэл 82,902 , - Гадаад тээврийн хэрэгсэл 205 байна. 2. Зорчигч, тээврийн хэрэгслийн статистик мэдээ тайланг сар улирлаар гаргасан. 3. Өдөр тутмын бүртгэлийн үйл ажиллагааны бүртгэлээр ААН-үүдийн бүс рүү орсон барааг сар бүрийн эцэст нэгтгэдэг үүнд 1-10 дугаар сарыг дууссан хугацаанд давхардсан тоогоор 225 ААН-ийн 8653,8 тн хүнсний бүтээгдэхүүн, ахуйн бараа, согтууруулах ундаа, тамхи, барилгын материал, “Гэми ЧБ” ХХК реэкспорт хийх буюу Солонгосоос ОХУ-руу гаргах автомашин зэрэг бараа бүтээгдэхүүнүүд нэвтэрсэн байна. 4. Бараа эргэлтийн тайлан статистик мэдээг аж ахуйн нэгжүүд 2022 оныг дуусахад гаргах бөгөөд 2022 оны бараа эргэлтийн статистик мэдээг боловсруулахад бэлтгэл ханган сар бүрийн тайланг нэгтгэж гаргасан. 2022.10-р сарыг дуусах байдлаар бүсэд орсон бараа дүнгээр 19 343 965.74\$, борлуулсан бараа 17 447 669.68\$ байна 5. 2022 онд чөлөөт бүсэд нэвтрэх хяналтын нарийн хуудсыг хэвлэн /22000001-22083000/ нэвтэрсэн хяналтын хуудсыг тухай бүр архивлаж байна.	100

				бараа – 12,410,813.4 2 ам доллар.			
4.19	Алтанбулаг чөлөөт бүсэд улсын төсвийн хөрөнгөөр баригдсан үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй дэд бүтцийн барилга байгууламж болон бусад хөрөнгийн ашиглалт, харуул хамгаалалт, засвар үйлчилгээ арчилгааг хариуцан, гэрээт ажилчдын харуул хамгаалалтад тогтмол хяналт тавьж ажиллах.	2,830,000 төгрөг /Урсгал засварын зардал/	Хяналтын үзлэгийн тайлан. Үр дүнгийн тайлан.	Жил бүр хийгддэг байнгын үйл ажиллагаа.	Барилга байгууламж, бусад эд хөрөнгөнд сар бүр тогтмол эргүүл үзлэг хийж, гарсан зөрчил доголдлыг тухай бүр арилгаж ажиллах.	<p>1. 2022.01, 02 03 сард бүсээс гарах, орох гарц, худалдааны зам талбайн халтиргаа гулгаа ихэссэн тул портер машинаар 21 удаа элс, хайрга зөөвөрлөж тараан асгаж халтиргаа гулгаанаас сэргийлж аюулгүй байдлыг ханган ажилласан.</p> <p>2. 2022.02.17-н Чөлөөт бүсийн ШНБ-ны гадна байрладаг зар мэдээллийн самбарыг буулган авчирч түр гарцны орох хэсэгт суурилуулж Чөлөөт бүсийн тухай хуулийн заалтууд, Хил хамгаалах байгууллага, Гаалийн байгууллагын мэдээлэл, бүс рүү нэвтэрч орох, гарах дарааллыг харуулсан зураглал орсон мэдээллийг байршуулсан.</p> <p>3. Чөлөөт бүсрүү төв замаас салах тэмдэг тэмдэглэгээ тавьж машин тэрэг зорчих боломжгүй хэсэг газрын замыг ковш трактороор түрүүлж тэгшлэв.</p> <p>4. Чөлөөт бүс руу орох урсгалын тусгаарлах төмөр хашлага салж унасныг гагнан засварлаж явган зорчигчдын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс орох, гарах явган хүний хаалга өөрсдийн нөөц бололцоог ашиглан хийлгэв.</p> <p>5. 2022 оны 02, 03, 04 саруудад нийт 8 удаа ЗАА-ны оффиссын байрны бохир усны шугам хоолой хөлдөж бөглөснийг мод авчирч галлан уураар гэсгээж хөлдүүс бөглөөсийг гаргаж 1ш суултуур эвдэрсэн байсныг сольж ЗАА, Гааль бусад байгууллагын ажилчдын ажиллах нөхцөл бололцоог хэвийн ханган ажилласан.</p> <p>6. 2022.03 сард Чөлөөт бүсийн 800мкүб усан сангийн гадна талд барьсан хашаа нурж унан шаардлага хангахгүй болсон тул хурааж нэг цэгт төвлөрүүлэв. Чөлөөт бүсээс гарах чиглэлд Гааль хилийн цэрэг хяналт шалгалт хийхэд шороо их босож ажиллах нөхцөл хүнд байсан учир өргөн 4м урт нь 15м 10см зузаантай бетон нь талбай мөн өргөн 2,5 урт нь 3,5-тай сүүдвэрч хийсэн.</p> <p>7. Сэлэнгэ аймаг дахь ЗАА-н байрны болон чөлөөт бүсийн гааль, оффисын байрнуудын өдөр тутам цэвэрлэгээ шатсан гэмтсэн ,гэрэл, чийдэн, солих ноолд ус шахах</p>	100

						<p>засварлах ажилуудыг цаг тухайд нь гүйцэтгэсэн.</p> <p>8. Оффисын байрны гадна орох хаалга дээр төмөр рам зангидаж салхи орохоос сэргийлж шилэн хаалт засвар үйлчилгээ хийв. Мөн байрны гаалийн 2 өрөө, шитний өрөөнүүдийн хаалга үүдийг замаск болон хөөс шахаж засварлаж цоож шинэчлэн сольсон.</p> <p>9. “Алтанбулаг” чөлөөт бүсийн 50м3 усан сан, өргөлтийн насос станцын байрны цонхыг шиллэх, чөлөөт бүсийн байрны бохирын худгийн бөглөрлийг гаргах, хашааны хогийг цэвэрлэж ачиж буулгах, хашааны хаалганы эвдрэлийг засах зэрэг өдөр тутмын аж ахуйн ажлыг гүйцэтгэж байна.</p> <p>10. “Алтанбулаг” чөлөөт бүсийн “Буурын гол”-ын хөндийд байрлах цэвэр усны эх үүсвэр болох 7-н худгийн доторхи байдал, мөн гадна хашааны үзлэг шалгалт хийсэн. 2.6-р худгийг ажиллуулах мөн боомтын замын ажил хийж байгаа хятад компанийг цахилгаанаар хангах шаардлагатай болсон.</p> <p>11. Сэлэнгэ аймаг дахь чөлөөт бүсийн конторын барилгад Сэлэнгэ аймгийн мэргэжлийн хяналтын газрын барилга хариуцсан улсын байцаагчаар дүгнэлт гаргуулж авсан. Учир нь уг барилгын ашиглалтын хугацаа дуусаж цаашид засвар хийх шаардлагатай байгаа.</p> <p>12. “Комфорт импекс” ХХК-ны хийж гүйцэтгэсэн бохир усны шугам хоолойн ажлыг 2022 оны 7-р сарын 29-нд шалгаж үзэхэд 12м шугам хоолой угсраагүй байсныг илрүүлж засварлуулсан.</p> <p>13. 2022.01, 02 сард 7 хоног тутам Аж ахуйн нэгжүүдийн нийт ажилтан болон бүсийн албан хаагчид хамтран бүсийн хашаан доторх цэвэрлэгээ, ААН-үүдийн дэлгүүрийн байр, ЗАА-ны оффисд ариутгал хийлгэх, 03 дугаар сард бүх нийтийг хамарсан гадна цэвэрлэгээ, 11 сард албан хаагчдын хамт бүсийн хашаанд хог хаягдал цэвэрлэсэн.</p>	
4.20	Бүсийн хашаанд тарьсан ногоон байгууламж болох мод, бут, зүлэг, таримал ургамал зэргийн арчилгааг хийх, цаг тухай бүрт гарсан тохижилт	-	Бүсийн ногоон байгууламжийн тоо, хэмжээ.	Тохижилт үйлчилгээний ажил байнга хийгддэг ажил.	Бүсийн ногоон байгууламжийн арчилгааг тогтмол хийх, тохижилт үйлчилгээ сайжирсан байна.	<p>1. Чөлөөт бүс дотор 6,2га талбайг тойруулж ЗАА, аж ахуйн нэгжүүд хамтран нийт 252 нарс мод тарьсан.</p> <p>2. Гаалийн байгууллагын бүртгэлийн хэсэгт мод зүлгийг хамгаалах, явган иргэдийг тусгаарлах хашаа бш-ийг барьсан.</p> <p>3. 2022.01-06 сарууд 7 хоног тутам Аж ахуйн нэгжүүдийн нийт ажилтан болон бүсийн албан хаагчид хамтран бүсийн хашаан доторх цэвэрлэгээ, ААН-үүдийн</p>	95

	үйлчилгээний ажлыг зохион байгуулах					дэлгүүрийн байр, ЗАА-ны оффиссд ариутгал, бүсийн дотор болон гадна нийтийн бие засах газрыг цэвэрлэн ариутгал хийлгэх ажлыг зохион байгуулж ажилласан. Бүсийн доторх хогийн цэгийн шатсан үнсийг 6 удаа сумын хогны машинаар гадагш тээвэрлүүлж хаях ажлыг зохион байгуулсан. 4. Оффиссын байрны өдөр тутмын усны хэрэглээг албан хаагчдын хувийн машинаар 7 хоногт 4-5 удаа 1тн-н саваар зөөвөрлөдөг бөгөөд давхар нөөц усны сав тавин ЗАА-н байрны усны хэрэгцээг ханган ажиллаж байна, 5. ЗАА, Аж ахуйн нэгжтэй хамтарсан 6,2га талбай дээр тарьсан мод ургамлыг өдөр тутам услах арчлах ажлыг зохион байгуулж нийт тарьсан модны 80% нь ургаж байна. Оффиссын гадна орчны таримал мод бут сөөгний зэрлэг ургамлыг хадаж цэвэрлэж байна.	
4.21	Чөлөөт бүсийн харуул хамгаалалтын хашаанд хяналт тавьж, сард 1-2 удаа хил хамгаалах 0101 дугаар ангийн алба хаагчидтай хамтарсан үзлэг хийж, эвдрэл гэмтлийг цаг тухайд нь засварлах.	-	Үзлэг хийсэн тэмдэглэл, засвар хийсэн тайлан.	Жил бүр хийгддэг байнгын үйл ажиллагаа.	Сард 1-2 удаа хил хамгаалах 0101 дугаар ангийн алба хаагчидтай хамтарсан үзлэг хийж, эвдрэл гэмтлийг цаг тухайд нь засварласан байна	Сард 1-2 удаа хил хамгаалах 0101 дугаар ангийн алба хаагчидтай хамтарсан үзлэг хийж нийт 2-6-р цэг хүртэл 14ш, 7-8 дугаар цэгийн хооронд 5ш, 9-10 дугаар цэгийн хооронд 8ш хашаа унасан болон эвдэрсэн ба сэлбэн зассан. 5,6-р цэгийн хооронд 2 хашаа 9-10 дугаар цэгийн хооронд 1ш, хашаа унасан болон эвдэрсэн ба сэлбэн зассан . Чөлөөт бүсийн хашааны дотор талд нь хилийн цэрэг мөр хянах зурвас татах зорилгоор техник оруулахад 2-р цэгийн харалдаа 2 хашаа түр салгаж буцаан гагнасан.	98
4.22	Бүс доторх цахилгаан хангамжийн трансформатор ерөнхий шит бусад 0,4 кВ-ын шитнүүд, 6 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам зэрэгт тогтмол үзлэг хийх, цахилгаан халаагууртай аж ахуй нэгжийн	3,220,000 төгрөг матер иалын зардал тооцоо /Байнгын үйл ажилл	Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ.	Жил бүр хийгддэг байнгын үйл ажиллагаа.	"ДСЦТС"-ийн хэсгийн байцаагчтай хамтран тоолуурын заалтыг сар бүр тогтмол авч ААН-үүдэд хүргүүлэн тооцоо хийлгүүлэн өрийн үлдэгдэлгүй	1. Бүсийн цахилгаан хангамжийн КТП-405 дугаар дэд станцын 0.4 кВ-ын хувиарлах шитний залгаж, салгах рубельник 2022.02.02-ны өдөр В фазад, 27-ны өдөр С фазад халалт үүсэж цаашид ашиглах боломжгүй болсон тул шинээр худалдан авч суурилуулан хэвийн байдалд оруулсан. 2. 2022.03.09 хүчтэй салхины улмаас КТП-424-ийн өндрийн хуурай салгуурын гарны холбогч боолт унасны улмаас буултын утасны А,В фазын хооронд наалдаж газардлага үүсгэснийг засварлаж гэмтлийг устгаж шугамыг хүчдэлд залгасан. 3. 2022.03.16 бүсийн 6 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамд газар шорооны ажил гүйцэтгэж байсан эксковатор гэмтэл гаргасан ба гэмтлийг устгаж шугамыг	98

	<p>найдвартай ажиллагааг хангаж, эрчим хүчний хэрэглээнд хяналт тавьж, “ДСЦТС”-ийн Сүхбаатар салбартай хамтран тоолуурын заалтыг тогтмол хянаж тооцоо хийх.</p>	<p>агаа явуулж буй ААН-үүдийн санхүүжилтэ эр/</p>			<p>байх, цахилгааны шитүүдэд гэмтэл үйл ажиллагааны доголдолгүй, ажиллах нөхцөл хангагдсан байна.</p>	<p>хүчдэлд залгасан. 4. Дээрхи гэмтлүүд гарч шугам хүчдэлгүй болсон үед шугамын трасст үзлэг хийж КТП-405, 424-ийн цэнэг шавхагч, өндрийн гал хамгаалагч, 0.4 кВ-ын ерөнхий автомат, ААН-үүдийн хуваарилах шитний ерөнхий автоматүүдэд чангалгаа хийсэн. 5. 25 км бохирын бкв цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуурыг газар шорооны ажил үйлчилгээ явуулж, гарсан гэмтэл зөрчлийг цаг тухайд нь арилгасан.</p>	
--	---	---	--	--	---	--	--

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Ч.ХҮРЭЛБААТАР/
(огноо)

Тэмдэг

.....

Төлөвлөгөө тайлагнасан:

Төсвийн Шууд захирагч

“АЛТАНБУЛАГ” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧ
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Г.ГАНЗОРИГ/
(огноо)

Тэмдэг

.....